3.1. Захиалагч нь хамгийн багадаа ажлын 5 хоногийн өмнө худалдан авах бараа түүнтэй холбогдох бараа тээвэрлэх үйлчилгээний захиалгыг Нийлүүлэгчийн "Захиалгын хуудас"-ны дагуу бөглөж, гарын үсэг тамга, тэмдгээр баталгаажуулан ирүүлнэ.

3.2. Нийлүүлэгч нь барааг Монгол улс, Улаанбаатар хот, Налайх дүүргийн нутагт орших Нийлүүлэгчийн тэсрэх материалын агуулах нөхцөлөөр талуудын тохиролцсон хугацаанд нийлүүлнэ.

3.3. Нийлүүлэгч барааг захиалагчид гэрээний 3.2-т заасан нөхцөлөөр гэрээний хавсралтаар баталгаажуулсан бараа хүлээлцэх актыг үйлдэж, шилжүүлэн өгснөөр барааг нийлүүлсэнд тооцно.

3.4. Захиалагч бүтээгдэхүүнийг Нийлүүлэгчийн агуулахаас авахдаа тухайн өдрийн 17:30 цагаас өмнө очиж авсан байна. Заасан хугацаанд барааг аваагүй тохиолдолд гарах зардлыг Нийлүүлэгч хариуцахгүй.

3.5. Захиалагч нь Уул уурхайн хүнд үйлдвэрлэлийн яамны салбарын хяналтын газраас олгосон Тээвэрлэх хуудасны дагуу, тухайн тоо ширхгээс илүү болон дутуу авахгүй байхаар тооцож тэсрэх материалын тээвэрлэлтийг зохион байгуулна.

3.6. Захиалагч нь тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг бүтээгдэхүүний хайрцаг, сав баглаа боодолд тааруулан, задгай бүтээгдэхүүн авахгүй байхаар зохион байгуулна.

3.7. Тэсрэх материал худалдан авах тоо хэмжээ нь хавсралт 3-т заасан тоо хэмжээгээр хязгаарлагдахгүй бөгөөд уурхайн төлөвлөгөөний дагуу нэмэгдэх боломжтой.

*Энэхүү гэрээ нь байгууллагын нууцад хамаарах мэдээлэл агуулж байгаа тул гуравдагч этгээдэд мэдээллийг ил болгох, дамжуулах, хувилж тараах, нийтийн хүртээл болгохыг хориглоно.*

## ДӨРӨВ. ЧАНАРЫН БАТАЛГАА

4.1. Энэхүү гэрээний дагуу Захиалагчид нийлүүлэгдэх бараа нь чанар стандартын болон техникийн нөхцөлд нийцсэн, түүнд тавигдах шаардлагыг хангасан байна.
4.2. Нийлүүлэгч нь Захиалагчид барааны чанарын баримт бичиг /чанарын сертификат, лабораторийн шинжилгээний бичиг/ -ийг барааны хамт олгоно.
4.3. Захиалагч барааг хүлээн авах үед Нийлүүлэгчийн бараанд чанарын доголдолтой, дутагдалтай бараа илэрсэн тохиолдолд түүнийг хүлээлцэх актад тусган, доголдолтой бүтээгдэхүүнийг Нийлүүлэгч өөрийн зардлаар шуурхай нөхөн олгоно. Барааг хүлээн авч тухайн салбараас хөдөлсөн тохиолдолд тус заалт хүчингүйд тооцогдоно.

## ТАВ.ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

5.1 Захиалагчийн эрх

5.1.1 Гэрээнд хавсаргасан чанар болон техникийн үзүүлэлт бүхий тэсрэх материалыг хугацаанд нь нийлүүлэхийг Нийлүүлэгчээс шаардах;
5.1.2 Нийлүүлэгчийн нийлүүлсэн бараанд чанарын доголдол илэрсэн тохиолдолд доголдлыг арилгуулах;
5.1.3 Нийлүүлэгчээс барааны сонголт, ашиглалт, хадгалах горим, тээвэрлэлтийн талаар зааварчилгаа, зөвлөгөө, мэдээлэл авах, бүтээгдэхүүн үйлчилгээний талаар сайжруулах санал өгч, хамтран ажиллах;
5.1.4 Захиалагч нь шаардлагатай тохиолдолд цаашид бараагаар хангуулах тухай гэрээнд хавсралтаар нэмэлт өөрчлөлт оруулах талаар хүсэлт гаргах.
5.1.5 Захиалагч нь тэсрэх материалтай холбоотой болон үйлчилгээний талаарх санал, гомдол гарсан тохиолдолд Нийлүүлэгч талд түүний албан ёсны цахим шуудан, албан бичиг болон бусад хэлбэрээр хүргүүлнэ;

5.2 Захиалагчийн үүрэг

5.2.1 Барааны захиалгыг энэхүү гэрээний 3.1–т заасан хугацаанд Нийлүүлэгчид цахим шуудангаар илгээх;
5.2.2 Барааны үнэ, төлбөрийг энэхүү гэрээний 2.2 -т заасан нөхцөл, 2.3 -т хугацаанд төлөх;
5.2.3 Барааг тээвэрлэх тээврийн хэрэгсэл, жолоочийн мэдээлэл /жолоочийн овог нэр, утасны дугаар, машины марк, улсын дугаар, машины даац гэх мэт/ -ийг бараа хүлээн авахаас 2 цагийн өмнө цахим шуудангаар Нийлүүлэгч талд хүргүүлсэн байх;
5.2.4 Барааг Нийлүүлэгчээр тээвэрлүүлэх тохиолдолд бараа тээвэрлэх хяналтын хуудсыг Нийлүүлэгчид захиалгын хамт хүргүүлэх;
5.2.5 Захиалагчийн төлөөлөгч нь барааг дагалдах хуудастай нэг бүрчлэн тулгаж, сав баглаа боодол, хайрцагийн бүрэн байдлыг шалгаж, чанарын гэрчилгээ, техникийн үзүүлэлтүүд, бараа хүлээлцэх акттай тулган, гарын үсэг зурж хүлээн авах;
5.2.6 Барааг хүлээн авснаас хойш түүний хадгалалт, хамгаалалт, ашиглалтын аюулгүй байдлыг хариуцах;
5.2.7 Барааны тээвэрлэлтийг хариуцах тохиолдолд холбогдох дүрэм, журам, стандартад нийцүүлэн тээвэрлэлтийг гүйцэтгэж, ашиглалтын зааврыг чанд мөрдөх;
5.2.8 Захиалагч нь тухайн сарын 25-ны өдрөөс өмнө ирэх сарын тэсрэх материалын худалдан авах захиалгыг ирүүлж байх үүрэгтэй.

5.3 Нийлүүлэгчийн эрх

5.3.1 Захиалагчаас гэрээний 2.3-т заасны дагуу хугацаанд нь төлбөрөө төлөхийг шаардах;
5.3.2 Гэрээгээр тохирсон хугацаанд төлбөрөө төлөөгүй тохиолдолд барааг нийлүүлэхгүй байх;

5.3.3 Захиалагчийг захиалгын дагуу барааг гэрээгээр тохирсон газар, хугацаанд нь хүлээн авахыг шаардах;
5.3.4 Захиалагч тээвэрлэлт хийх тохиолдолд тухайн тээврийн хэрэгсэл аюултай ачаа тээвэрлэх зөвшөөрөлтэй эсэх холбогдох шаардлага хангасан эсэхийг шалгах;
5.3.5 Захиалагч Нийлүүлэгчид урьдчилан мэдэгдэлгүйгээр захиалгаас татгалзсан тохиолдолд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх;
5.3.6 Захиалагч нь гэрээнд заасан хугацаанд бараа бүтээгдэхүүн үйлчилгээний захиалгыг ирүүлээгүй, хэт тулган өгсөн төлөвлөгөө, захиалгыг биелүүлэх боломжгүй бол тус захиалгыг хүлээн авахгүй байх, хойшлуулах;

5.4 Нийлүүлэгчийн үүрэг

5.4.1 Захиалагчид энэхүү гэрээнд хавсаргасан чанар болон техникийн үзүүлэлт бүхий барааг эрх бүхий байгууллагаас олгосон баримт бичиг, зөвшөөрлийн дагуу хугацаанд нь найдвартай нийлүүлэх;
5.4.2 Захиалагчийн захиалгын дагуу барааг тээвэрлэх тохиолдолд Захиалагчийн ирүүлсэн хяналтын хуудсанд үндэслэн маршрут болон олгох хуудсыг бэлтгэж ажиллах;
5.4.3 Нийлүүлэгч нь барааг Захиалагчид энэхүү гэрээний 3.2-т заасан нөхцөлөөр нийлүүлэх хүртэлх түүний хадгалалт, хамгаалалт, тээвэрлэлтийн аюулгүй байдлыг хариуцах;
5.4.4 Чанарын доголдолтой аливаа бүтээгдэхүүнийг гэрээний дагуу сольж, нөхөн олгох;
5.4.5 Бүтээгдэхүүний техникийн тодорхойлолт, хор аюулгүй байдлын зааварчилгаа шинэчлэгдэн, өөрчлөгдөх бүрд харилцагчид илгээх;

## ЗУРГАА. ТАЛУУДЫН ХАРИЛЦАН ХҮЛЭЭХ ЭРХ, ҮҮРЭГ

6.1. Талуудын эрх

6.1.1. Гэрээний үүргийн биелэлттэй холбоотой санал, гомдлыг шийдвэрлүүлэх;
6.1.2. Гэрээ байгуулснаас хойш гэрээний үүргээ зохих ёсоор биелүүлээгүй, эсхүл үүргийнхээ дийлэнх хэсгийг биелүүлж чадахгүй бодит нөхцөл бий болсон тохиолдолд талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхээс татгалзах;

6.2. Талуудын үүрэг

6.2.1. Гэрээний үүргээ шударгаар биелүүлэх;
6.2.2. Холбогдох хууль, дүрэм, журам, стандартыг чанд мөрдөх;
6.2.3. Гэрээний үүргээ биелүүлэхтэй холбоотой баримт бичгийн бүрдлийг хангах;
6.2.4. Гэрээний эрх, үүрэг хариуцлагыг бусдад шилжүүлэхгүй байх;
6.2.5. Захиалагч тэсрэх материал худалдан авахтай холбоотой төлбөрийг бүрэн хариуцна;

## ДОЛОО. ХАРИУЦЛАГА

7.1. Нийлүүлэгч нь гэрээний дагуу өгч баталгаажуулсан захиалгыг хоцроосон тохиолдолд барааг хоцроосон хоног тутамд тухайн бараанд ноогдох төлбөрийн 0.1 хувьтай тэнцэх хэмжээний алдангийг Захиалагчид төлнө. Захиалагч 3.1-д заасан хугацаанаас бага хугацаанд захиалсан тохиолдолд энэ заалт хүчингүйд тооцно.
7.2. Захиалагч нь Нийлүүлэгчээс гэрээгээр заасан хугацаанд төлбөр төлөх үүргээ биелүүлэлгүй хугацаа хэтрүүлсэн тохиолдолд ийнхүү хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.1 хувьтай тэнцэх хэмжээний алдангийг Нийлүүлэгчид төлнө.
7.3. Захиалагч Нийлүүлэгчид урьдчилан мэдэгдэлгүйгээр захиалгаас татгалзсан тохиолдолд учирсан хохирлыг нөхөн төлнө.
7.4. Учирсан хохирол гэдэгт Талууд гэрээний үүргээ биелүүлээгүй эсвэл зохих ёсоор биелүүлээгүйн улмаас аль нэг талд гуравдагч этгээдээс гаргасан гомдлын шаардлагыг хангахтай холбоотой зардал, өөрт учирсан бодит болон бодит бус хохирлыг ойлгоно.

*Энэхүү гэрээ нь байгууллагын нууцад хамаарах мэдээлэл агуулж байгаа тул гуравдагч этгээдэд мэдээллийг ил болгох, дамжуулах, хувилж тараах, нийтийн хүртээл болгохыг хориглоно.*

7.5. Талууд Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу хүлээсэн үүргээ зөрчсөний улмаас үүсэх хариуцлагыг хуульд заасан хэмжээгээр хариуцна.

7.6. Талууд нийлүүлэлт хийхтэй холбоотойгоор туслан гүйцэтгэгч ажиллуулах шаардлагатай нөхцөл үүссэн тохиолдолд харилцан зөвшилцөж, бичгээр баталгаажуулна.

7.7. Худалдан авсан түүхий эд, тэсрэх бодисын үлдэгдэл, сав баглаа боодол нь химийн аюултай бодис, аюултай хог хаягдалд хамаарах тул холбогдох хууль, эрх бүхий төрийн байгууллагаас гаргасан дүрэм, журмын дагуу устгах эсхүл өмчлөлийг тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжид гэрээгээр шилжүүлэн устгуулах үүргийг хүлээх ба үүнтэй холбоотой гарах зардлыг бүрэн хариуцна.

7.8. Худалдан авсан түүхий эд, тэсрэх бодисын үлдэгдэл, сав баглаа боодол нь химийн аюултай бодис, аюултай хог хаягдлыг ил задгай хаях, хууль, журмын дагуу устгаагүйгээс үүдэн хүний эрүүл мэнд, амь нас, байгаль орчинд учирсан болон учирч болзошгүй аливаа хохирлыг захиалагч тал хариуцна.

7.9. Захиалагч нь гэрээний үүргээ бүрэн хариуцах ба өөр компанид шилжүүлэхийг хориглоно.

7.10. Захиалагч нь тэсрэх материалын тээвэрлэлтийг нийлүүлэгчээр хийлгээгүй тохиолдолд нийлүүлэгч тал хариуцлага хүлээхгүй.

## НАЙМ. ГЭРЭЭНИЙ НУУЦЛАЛ

8.1. Энэхүү гэрээ болон талуудын өөр хоорондоо солилцсон аливаа бусад мэдээлэл нь нууц байх бөгөөд хуульд зааснаас бусад тохиолдолд мэдээллийн нууцлалыг хангах үүрэгтэй. Нууц мэдээлэлд талуудын аман болон бичиг, цахим хэлбэрээр солилцож олж авсан гэрээлэгч талын бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ, өртгийн мэдээлэл, санхүүгийн мэдээлэл, талуудын хооронд энэхүү гэрээний хүрээнд тохиролцсон нөхцөлүүд болон бусад гэж тэмдэглэгдсэн баримт бичиг, агуулгууд хамаарна.

8.2. Талууд нууц мэдээллийг өөрийн холбогдох ажилтнуудад тэдгээрийн ажил, үүрэгтэй холбоотойгоор мэдээлж болох бөгөөд энэ тохиолдолд тэдгээр ажилтнууд энэ гэрээнд заасан нууц хадгалах үүргийг чандлан биелүүлэх үүргийг давхар хүлээнэ.

## ЕС. ГЭНЭТИЙН БОЛОН ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

9.1 Гэрээний аль нэг тал дурдсан нөхцөл байдлын улмаас гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл бий болсон гэдгийг нотолж, түүний улмаас учирсан хохирлыг болон тэргүүн ээлжид биелүүлбэл зохих үүргүүдээ аль болох богино хугацаанд биелүүлэхийг эрмэлзэж, шаардлагатай бүх алхмуудыг хийх үүрэгтэй ба гэрээний нөгөө тал гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн улмаас үүргээ гүйцэтгэх боломжгүй байгаа нь нотлогдсон тохиолдолд нөгөө талдаа гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжит хугацаа олгох үүрэгтэй.

9.2 Гэрээний аль нэг талд Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн танхимаас олгосон дээрх нөхцөл байдал үүссэнийг баталсан бичиг баримт нь уг нөхцөл байдал үүссэн болон үргэлжилж буйг нотлох нотолгоо болно.

9.3 Гэрээ нь аль нэг тал холбогдох, хууль дүрэм журам, орон нутаг, засаг захиргаатай байгуулсан гэрээний өмнө хүлээсэн үүрэг хариуцлагаа биелүүлээгүй улмаас гарсан аливаа үймээн самуун, бослого, төрийн байгууллага, шүүх хяналтын байгууллагын арга хэмжээ нь давагдашгүй хүчин зүйлд тооцогдохгүй болно.

9.4 Гэнэтийн давагдашгүй хүчин зүйлс бий болсон нь 30 хоногоос дээш хугацаагаар үргэлжилбэл Талууд асуудлыг харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.

9.5 Гэнэтийн давагдашгүй хүчин зүйл гэдэгт гал түймэр, газар хөдлөлт, салхи шуурга, аянга цахилгаан, үер усны гамшиг зэрэг байгалийн гамшиг, нийтийг хамарсан үймээн, эсэргүүцлийн хөдөлгөөн, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэр, хорио, цээр зэрэг талуудын хүсэл зоригоос үл хамаарах шалтгаануудыг ойлгоно.

9.6 Гэнэтийн давагдашгүй хүчин зүйл учирсан тохиолдолд гэрээнд заасны дагуу талууд шуурхай арга хэмжээ авч, зохицуулалт хийж хамтран ажиллана.

*Энэхүү гэрээ нь байгууллагын нууцад хамаарах мэдээлэл агуулж байгаа тул гуравдагч этгээдэд мэдээллийг ил болгох, дамжуулах, хувилж тараах, нийтийн хүртээл болгохыг хориглоно.*

## АРАВ. ГЭРЭЭГ ЦУЦЛАХ, НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ

10.1. Талууд гэрээг зөрчсөнөөс бусад тохиолдолд энэхүү гэрээг нэг талын шийдвэрээр цуцалж болохгүй.

10.2. Талууд дараах нөхцөлд гэрээг цуцлах үндэслэл бүрдэнэ. Үүнд:

10.2.1 Төлбөрийг гэрээнд заасан хугацаанаас 30 буюу түүнээс дээш хоног хойшлуулж, төлбөр төлөөгүй бол Захиалгат барааг урьдчилгаа төлбөр төлснөөс хойш Захиалагчийн үйл ажиллагаанаас хамаарахгүйгээр энэхүү гэрээгээр тохирсон хугацаанд удаа дараа нийлүүлээгүй;

10.2.2 Талуудын өгсөн мэдээлэл, хүргүүлсэн тайлан мэдээ, баримт бичиг нь худал, хуурамч, бодит байдлаас зөрүүтэй болох нь тогтоогдсон;

10.2.3 Хууль тогтоомж зөрчсөн тохиолдолд зөрчлийг арилгах талаар бичгээр шаардлагыг 2-оос дээш удаа тавьсан боловч шаардлагыг хүлээн авсан тал зөрчлийг товлосон хугацаанд арилгаагүй бол гэрээг цуцлах мэдэгдлийг дахин хүргүүлж, гэрээг цуцалж болно.

10.3. Талууд гэрээний хугацааг сунгах, нэмэлт болон өөрчлөлт оруулах тухай саналыг 14 өдрийн өмнө, гэрээг дуусгавар болгох, цуцлах тухай мэдэгдлийг 30 өдрийн өмнө нөгөө талдаа бичгээр өгнө.

10.4. Гэрээний нэмэлт, өөрчлөлт болон хавсралтууд нь талуудын эрх бүхий төлөөлөгчид харилцан бичгээр гарын үсэг зурж баталгаажилтаар хүчин төгөлдөр болох бөгөөд гэрээний салшгүй хэсэг болно.

10.5. Гэрээний зүйл заалтууд, нэмэлт өөрчлөлт, хавсралтууд дахь нөхцөлүүд нь дараагийн нэмэлт өөрчлөлтүүдээр өөрчлөгдөөгүй тохиолдолд батлагдсан өдрөөсөө эхлэн гэрээний бүхий л хэсэгт хүчин төгөлдөр үйлчилнэ.

## АРВАН НЭГ. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

11.1. Талууд энэхүү гэрээтэй холбоотой аливаа санал зөрөлдөөн, маргааныг харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэхийг эрмэлзэнэ.

11.2. Талууд гучин (30) өдрийн дотор маргааныг шийдвэрлэж чадаагүй тохиолдолд Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

## АРВАН ХОЁР. БУСАД ЗҮЙЛ

12.1 Энэхүү гэрээ нь Талуудын төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх захирал, хувьцаа эзэмшигчид эсхүл үүсгэн байгуулагч нар солигдохоос үл хамааран хүчин төгөлдөр хэвээр байна.

12.2 Энэхүү гэрээ нь Талуудын эрх залгамжлагч болон тэдгээрийн эрхийг шилжүүлэн авагч нарын хувьд заавал биелэгдэх шинжтэй байна.

12.3 Энэхүү гэрээний үйлчлэл нь Талууд гарын үсэг зурж, тамга дарж баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болж Талууд тус тусын хүлээсэн үүргийг бүрэн биелүүлснээр дуусгавар болно.

12.4 Энэхүү гэрээг Монгол хэл дээр 2 хувь үйлдэх бөгөөд энэ нь хуулийн өмнө хүчин төгөлдөр байна.

12.5 Талууд цахим харилцааг ашиглан захиалга, гэрээ болон хамтын үйл ажиллагаатай холбоотой аливаа асуудлуудыг доорх цахим хаягуудаар холбогдож баталгаажуулж байна. */Цахим мэдээллийг хүснэгт 2 –т харуулав/*

*Хүснэгт 2.*

| **Нийлүүлэгч** | | **Үндсэн захиалагч, Захиалагч** | |
|---|---|---|---|
| Борлуулалт, бизнес хөгжил хариуцсан захирал Г.Хатантөмөр | + (976) -99996767 *Khatantumur.g@mera.mn* | Захирал Т.Төмөрсоль | +(976)- 88114980 |
| Ерөнхий нягтлан бодогч Л.Болдбаатар | +(976) -98102828 *Boldbaatar.Lh@mera.mn* | Санхүү хариуцсан менежер Б.Энхбаатар | +(976)-88114960 |

*Энэхүү гэрээ нь байгууллагын нууцад хамаарах мэдээлэл агуулж байгаа тул гуравдагч этгээдэд мэдээллийг ил болгох, дамжуулах, хувилж тараах, нийтийн хүртээл болгохыг хориглоно.*

| | | | |
|---|---|---|---|
| Борлуулалтын мэргэжилтэн Э.Баасанбат | + (976) -89618160 Baasanbat.e@mera.mn | | |

**ГЭРЭЭГ БАТАЛГААЖУУЛСАН:**

***Захиалагч:***

"Үнэн-Анд" ХХК-ийн
Захирал Т.Төмөрсоль

____________________/гарын үсэг/

***Нийлүүлэгч:***

"МЕРА" ХХК-ийн
Гүйцэтгэх захирал С.Баярсайхан

____________________/гарын үсэг/

ГЭРЭЭГ ХЯНАСАН:

Санхүү хариуцсан менежер
Б.Энхбаатар

____________________/гарын үсэг/

Борлуулалт, бизнес хөгжил хариуцсан захирал Г.Хатантөмөр

____________________/гарын үсэг/

Санхүү, хөрөнгө удирдлага хариуцсан захирал
Б.Должинсүрэн

____________________/гарын үсэг/

Хуульч
А.Ариунболд

ХУУЛЬЧ ХЯНАВ
Гарын үсэг: ....................
Огноо: ....................

____________________/гарын үсэг/

*Энэхүү гэрээ нь байгууллагын нууцад хамаарах мэдээлэл агуулж байгаа тул гуравдагч этгээдэд мэдээллийг ил болгох, дамжуулах, хувилж тараах, нийтийн хүртээл болгохыг хориглоно.*

**2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн**
**№ MR24/62 тоот гэрээний хавсралт №1**

1. **Барааны үнэ**

| № | Тэсрэх материалын төрөл | Тэсрэх материалын нэр | Хэмжих нэгж | Нэгж үнэ ₮ /НӨАТ ороогүй/ |
|---|---|---|---|---|
| 1 | Савласан эмульсийн тэсрэх бодис | ANDO-V 90мм, ХБ | кг | 4,200 |
| 2 | Энгийн тэсрэх бодис | Аянга 25кг | | 1,850 |
| 3 | Далдын холбох хэрэгсэл | МЕРА шокстар LP 10мс | ш | 23,000 |
| 4 | Гадаргын холбох хэрэгсэл | МЕРА шокстар SF 10мс | | 14,000 |
| 5 | Цочир дамжуулах шижим | ДШЭ-12гр | м | 2,100 |
| 6 | Хавчаар | Хэрэгслийн хавчаар | ш | 500 |

**ХАВСРАЛТ БАТАЛГААЖУУЛСАН:**

**Захиалагч:**

"Үнэн-Анд" ХХК-ийн

Захирал Т.Төмөрсоль

Т.Төмөрсоль /гарын үсэг/

**Нийлүүлэгчийг төлөөлж:**

"МЕРА" ХХК-ийн

Гүйцэтгэх захирал С.Баярсайхан

/гарын үсэг/

*Энэхүү гэрээ нь байгууллагын нууцад хамаарах мэдээлэл агуулж байгаа тул гуравдагч этгээдэд мэдээллийг ил болгох, дамжуулах, хувилж тараах, нийтийн хүртээл болгохыг хориглоно.*

**2024 оны 04 дүгээр сарын 26–ны өдрийн**
**№ MR 24/62 тоот гэрээний хавсралт №2**

**Бараа хүлээлцэх акт:**

| № | Тэсрэх материалын нэр | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | |
|---|---|---|---|---|
| | | | Тоогоор | Үсгээр |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |

**ХАВСРАЛТ БАТАЛГААЖУУЛСАН:**

**Тэсрэх материал олгосон:**

“МЕРА” ХХК-ийн

Салбарын нярав

____________________/гарын үсэг/

**Тэсрэх материал хүлээн авсан:**

“Үнэн-Анд” ХХК-ийн

Ахлах тэсэлгээчин С.Үенбаатар

____________________/гарын үсэг/

*Энэхүү гэрээ нь байгууллагын нууцад хамаарах мэдээлэл агуулж байгаа тул гуравдагч этгээдэд мэдээллийг ил болгох, дамжуулах, хувилж тараах, нийтийн хүртээл болгохыг хориглоно.*

**БАТЛАВ. "АЗИЙН ТОП ЭХЛЭЛ" ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ**

**П.ЭРДЭНЭБАТ**

**БАТЛАВ. "ҮНЭН АНД" ХХК-ИЙН ЗАХИРАЛ**

**Т.ТӨМӨРСОЛЬ**

# ХАРУУЛ ХАМГААЛАЛТЫН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ГЭРЭЭ

2024 оны 04-р сарын 02-ны өдөр № АТ2024/21 Улаанбаатар хот

Энэхүү гэрээг (цаашид "Гэрээ" гэх) Монгол Улсын Иргэний хуулийн 476-480-р зүйл, Гэрээт харуул хамгаалалтын тухай хуулийн 8-р зүйл болон бусад хууль тогтоомжийн хүрээнд:

Нэг талаас "АЗИЙН ТОП ЭХЛЭЛ" ХХК Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 3-р хороо, Энхтайваны өргөн чөлөө, VIP оффис 501 тоотод байрлах, Улсын бүртгэлийн 9011371004 дугаарт бүртгэгдсэн, регистрийн 5633362 дугаартай, Хууль зүй, дотоод хэргийн яамны 202307000043 дугаартай харуул хамгаалалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй (цаашид **"Хамгаалагч"** тал гэх) нь энэхүү гэрээнд заасан гэрээт харуул хамгаалалтын үйлчилгээг үзүүлэх хүний нөөц болон санхүүгийн чадавхтай болохоо илэрхийлж гэрээний нөхцөлийг зөвшөөрөн Хамгаалагч талыг төлөөлж Гүйцэтгэх захирал П.Эрдэнэбат,

Нөгөө талаас "ҮНЭН АНД" ХХК, 2885565 тоот регистрийн дугаартай (цаашид **"Үйлчлүүлэгч"** гэх) нь Дундговь аймгийн Баянжаргалан сум, Мануулт нэртэй газар байрлах тэсрэх материалын агуулахад харуул хамгаалалтын үйлчилгээ авах, объектыг гэмт халдлагаас хамгаалах, агуулахад мөрдөх дүрэм журмыг мөрдүүлэх, учирч болзошгүй аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор гэрээнд заасан нөхцөлөөр харуул хамгаалалтын үйлчилгээг авч төлбөр төлөхийг хүлээн зөвшөөрсөн Үйлчлүүлэгчийг төлөөлж Захирал Т.Төмөрсоль нар харилцан тохиролцож, гэрээнээс үүдэн гарах үр дагаврыг хүлээн зөвшөөрч байгуулав.

## НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Энэхүү гэрээний зорилго нь Хамгаалагч тал нь Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт байрлах "Үнэн Анд" ХХК-ийн тэсрэх материалын агуулахыг энэ гэрээ болон холбогдох хууль тогтоомжийн дагуу гэмт халдлагаас хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулж, талуудын эрх, үүрэг хариуцлагыг тодорхойлоход оршино.

1.2 Талууд хамтран ажиллахдаа Монгол Улсын Үндсэн хууль, Гэрээт харуул хамгаалалтын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийг мөрдлөг болгон ажиллана. Ийнхүү ажиллахдаа талууд харилцан нөгөө талын ашиг сонирхолыг хүндэтгэн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж, үйл ажиллагаандаа хууль дээдлэх, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, албаны болон хувийн нууцыг чанд сахих зарчмыг баримтална.

1.3 Энэхүү гэрээнд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно.

a) **"Үйлчилгээ"** гэж энэхүү гэрээ болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан арга хэлбэрээр Үйлчлүүлэгчийн объектыг гэмт халдлага, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчлийг таслан зогсоож хамгаалахыг;

b) **"Объект"** гэж /"Үнэн Анд" ХХК-ийн Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт байрлах тэсрэх материалын агуулахын объект болон бусад харуул хамгаалалтад авсан барилга байгууламж, түүнд хамаарах тодорхой орчин, газар нутаг, эд хөрөнгийг;

c) **"Үйлчлүүлэгч"** гэж энэхүү гэрээний үндсэн дээр Үйлчилгээ үзүүлэгчээс харуул хамгаалалтын үйлчилгээ авч байгаа иргэн, хуулийн этгээдийг;

d) **"Хамгаалагч тал"** гэж Гэрээт харуул хамгаалалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй буюу эрх бүхий байгууллагад бүртгүүлж, энэхүү гэрээний үндсэн дээр харуул хамгаалалтын үйлчилгээг үзүүлж байгаа этгээдийг;

e) **“Харуул хамгаалалтын алба хаагч”** гэж харуул хамгаалалтын байгууллагад харуул хамгаалалттай холбоотой тодорхой үүрэг гүйцэтгэж буй этгээдийг тус тус ойлгоно.

1.4 Энэ гэрээнд оруулсан нэмэлт, өөрчлөлт, хавсралтууд нь гэрээний салшгүй хэсэг болох ба энэхүү гэрээний нэгэн адил хүчинтэй үйлчилнэ.

## ХОЁР. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

2.1 Энэхүү гэрээг **2024** оны **04-р** сарын **11-ний** өдрөөс эхлэн **1** /нэг/ жилийн хугацаатай байгуулав.

2.2 Гэрээний хугацаа дуусахад гэрээг талууд хамтран дүгнэж, талуудын хэн нэг нь гэрээг дуусгавар болгон цуцлах талаар санал тавиагүй бол энэхүү гэрээг анх байгуулсан хугацаагаар сунгагдсанд тооцно.

2.3 Талууд гэрээний биелэлтийг улирал тутам дүгнэж, гэрээг хэрэгжүүлэх арга хэмжээний талаар ярилцан тохиролцож байна.

## ГУРАВ. ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ

3.1 Харуул хамгаалалтын алба хаагч гэрээгээр тохирсоноос бага хугацаагаар ажилласан тохиолдолд төлбөрийг ажилласан хугацаанд тохируулан хувь тэнцүүлэн олгоно.

3.2 Нэхэмжлэхийг сар бүрийн 01-ний өдөр мэйл хаягаар илгээнэ.

3.3 Нэг сарын хугацаанд нийт 2 хамгаалагч ажиллах бөгөөд нэг хамгаалагчийн 1 сарын гэрээний төлбөр 2,000,000 /хоёр сая/ төгрөг, нийт 2 хамгаалагчийн 1 сарын төлбөр 4,000,000 /дөрвөн сая/ төгрөг байна. Уг үнэд НӨАТ ороогүй болно. Төлбөрийг дараа сарын **05**-ны өдрийн дотор **“Азийн топ эхлэл”** ХХК-ийн ХААН банкны **5133293793** тоот дансанд шилжүүлнэ. Энэхүү үнийн дүнд объектод үүрэг гүйцэтгэж буй хамгаалалтын алба хаагчийн нэг бүрийн тусгай хэрэгсэл, бичиг хэргийн зардал, албаны дүрэмт хувцас, тээврийн зардал, хяналт шалгалтын шатах тослох материалын зардал тус тус багтсан болно.

3.4 Талууд улирал бүр тооцоо нийлсэн акт үйлдэнэ.

3.5. Харуул хамгаалалтын үйлчилгээний нэг сарын төлбөрийг заасан хугацаанаас шалтгаангүй хожигдуулсан тохиолдолд нэг хоног тутамд үнийн дүнгийн 0,5 хувиар алданги тооцно.

3.6. Нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, гэнэтийн халдлага, дайралт, зохион байгуулалттай бүлэг этгээдүүд, хутга мэс, мод чулуу болон галт зэвсгээр зэвсэглэсэн бусад олныг хамарсан хурал цуглаан шоу тоглолт зэрэг зайлшгүй нэмэгдэл хүч ажиллуулах шаардлагатай үед Хамгаалагч талаас гэрээнд заасан үндсэн хамгаалагчдын тоон дээр нэмэлт хүчээр хамгаалагчид татан ажиллуулах ба үйлчлүүлэгч тал нь үндсэн болон нэмэгдэл хамгаалагч тус бүрд гэрээнд заагдсан суурь үнийн дүнгийн 30% тэнцэхүйц төгрөгийг гэрээний төлбөр дээр нэмж Хамгаалагч талд төлнө. Энэхүү төлбөрт хамгаалалтын объект руу ирж очих автомашин, шатахуун, хоол хүнс, тусгай хэрэгслийн зардал багтсан болно.

3.7. Объектод үүрэг гүйцэтгэж байгаа харуул хамгаалалтын ажилтны амрах байр, хоолыг Үйлчлүүлэгч тал хариуцана.

## ДӨРӨВ. ХАМГААЛАГЧ ТАЛЫН БҮТЭЦ

4.1 Объектын гадна болон дотор хамгаалалтыг 24 цаг буюу нэг хоногт **1** /нэг/ хамгаалалтын алба хаагч хариуцаж ажиллана.

4.2 Объектод нийт **2** алба хаагч байрлаж ажиллана.

## ТАВ. ШУУРХАЙ ХАМГААЛАЛТЫН БҮЛЭГ

5.1. Шуурхай хамгаалагч нь объектод гэмт хэрэг, хэв журмын зөрчил гарсан үед 24 цагаар дуудлагаар ирж үүрэг гүйцэтгэнэ.

5.2. Гэмт хэрэг /хулгай, дээрэм, зэвсэгт халдлага г. м/

5.3. Хэв журмын зөрчил нь:

5.3.1 Хүнд /архидан согтуурсан, сэтгэцийн өвчтэй этгээдийн хэв журам зөрчсөн үйлдэл гэх мэт/

5.3.2 Хөнгөн /хэрүүл маргаан гэх мэт бусад/ жижиг зөрчлүүд

## ЗУРГАА. ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

**Үйлчлүүлэгчийн эрх**

6.1 Харуул хамгаалалтын алба хаагчийн үйл ажиллагаа, харилцааны соёлд хяналт тавьж, зөрчил дутагдал илэрвэл хамгаалалтын албанд даруй мэдэгдэж, шаардлага тавих.

6.2 Хамгаалалтын алба хаагчдыг шууд удирдлагаар ханган ажиллах.

6.3 Харуул хамгаалалтын байдал, гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилтэд хяналт тавих.

6.4 Харуул хамгаалалтын алба хаагч нь үүргээ хангалтгүй биелүүлсэн гэж үзвэл алба хаагчийг солих шаардлага тавих эрхтэй бөгөөд Хамгаалагч тал нь энэхүү шаардлагыг биелүүлэх үүрэгтэй.

6.5 Шаардлагатай үед хүч нэмэгдүүлсэн хамгаалалт авах, шуурхай бүлэг дуудан ажиллуулах.

**Үйлчлүүлэгчийн үүрэг:**

6.6 Хамгаалалтанд авагдсан объектыг актаар харуул хамгаалалтын албанд хүлээлгэн өгөх.

6.7 Харуул хамгаалалтын алба хаагчийн гүйцэтгэх үүргийг танилцуулж, заавар зөвлөмжөөр хангах.

6.8 Хамгаалалтын үйлчилгээний хөлсийг гэрээнд заасны дагуу саадгүй төлж байх.

6.9 Хамгаалагч тал /алба хаагч/-д өөрийн байгууллагад гарсан өөрчлөлт, хөдөлгөөнийг цаг алдалгүй шуурхай тухай бүр нь мэдэгдэж байх үүрэгтэй. Үүнд:

- Үйлчлүүлэгчийн холбогдох албан тушаалтнуудын холбоо барих утасны жагсаалтуудыг гаргаж өгөх, мөн ажлын бус цагаар нэвтрэх эрх бүхий албан тушаалтан болон тээврийн хэрэгслийн жагсаалтыг гаргаж өгнө.
- Обьектод барилгын засвар хийх, тоног төхөөрөмж, овор ихтэй эд хогшлын байршлыг солих
- Ажлын цагийн хуваарийн өөрчлөлт
- Объектыг нээх, хаах үүрэгтэй болон байгууллагын бусад ажилтнууд солигдох тохиолдолд
- Барилга байгууламжийн цонхны бэхэлгээ, гадна дотно хаалганы цоож, лац, ломбо гэх мэтийг өөрчлөх.

6.10 Хариуцаж байгаа тус объект дээр өдөр тутам тоолж, ширхэгчлэн хүлээж авах боломжгүй байнгын хөдөлгөөнтэй бараа материал зэргийг хариуцсан тодорхой албан тушаалтантай байх.

6.11 Үйлчлүүлэгч тал нь өөрийн эд хөрөнгийг хүлээлгэн өгнө.

6.12 Харуул хамгаалалтын алба хаагчийг харуулын байраар хангана.

6.13 Байгууллагын холбогдох ажилтнуудын хаягийн бүртгэл, хамгаалалтад байгаа объектод байнга нэвтрэх эрх бүхий хүмүүсийн болон эд хөрөнгөтэй харьцах, тэдгээрийг захиран зарцуулах эрх бүхий хүмүүсийн нэрсийг өгөх, өөрчлөгдсөн даруй Хамгаалагч талд мэдэгдэх.

6.14 Байгаа эд хөрөнгө, объектын хамгаалалтад шаардагдах гал унтраах болон бусад тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, хамгаалалтад шаардагдах гэрэлтүүлэгчээр 24 цаг хангах, хяналт тавьж, ажил тарсны дараа хэрэгцээгүй цахилгаан хэрэгслүүдийг хүчдэлээс салгасан байх.

6.15 Хамгаалагч /хамгаалалтын алба хаагч/-ийн зүгээс гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох талаар тавьсан хууль ёсны санал, шаардлагыг тухай бүрд нь хүлээн авч шийдвэрлэх.

6.16 Гэмт халдлага, хор аюул учруулж болзошгүй талаар сэжиг бүхий мэдээ мэдээлэл авмагц хамгаалалтын албанд нэн даруй мэдэгдэх, шаардлагатай арга хэмжээг хамтран авах.

6.17 Хамгаалалтын алба хаагчдад гэрээнд заагдсан үндсэн үүрэг ба ажил үүргийн хуваарьт зааснаас өөр бусад ажил үүрэг даалган гүйцэтгүүлэхгүй байх.

6.18 Хамгаалалтад өгсөн барилга байгууламж болон тодорхой орчин газарт гадны байгууллагын хамгаалалтын үйлчилгээг давхардуулахгүй байх.

6.19 Үйлчлүүлэгч талын эрх бүхий албан тушаалтан өөрийн объектоос эд зүйл гадагш гаргах тохиолдолд Хамгаалагч талын ажилтанд бичиг /зөвшөөрлийн хуудас/-ээр мэдэгдэж байна. Хэрэв Хамгаалагч талын ажилтан Үйлчлүүлэгч талын зөвшөөрөлгүйгээр хамгаалалтын объектоос эд зүйл гадагш гаргасан тохиолдолд Хамгаалагч тал бүрэн хариуцлага хүлээнэ.

## ДОЛОО. ХАМГААЛАГЧ ТАЛЫН ЭРХ, ҮҮРЭГ

Доорх хэсэгт дурдсан холбогдох эрх, үүргийг Хамгаалалтын алба хаагчийн эрх, үүрэг гэж давхар ойлгоно.

**7.1 Хамгаалагч талын эрх**

7.1.1 Хамгаалж байгаа эд хөрөнгө объектын талаар шаардлагатай мэдээлэл авах, түүнд тохирсон хамгаалалт зохион байгуулах талаар харилцан мэдээлэл солилцон ажиллах.

7.1.2 Хамгаалж байгаа эд хөрөнгийн хадгалалт хамгаалалтыг сайжруулахтай холбогдсон саналыг Үйлчлүүлэгчид тавих.

7.1.3 Харуул хамгаалалтын үүрэг гүйцэтгэхтэй холбогдуулан өөрийн хяналтын талбайд нэвтэрсэн этгээдийн бичиг баримт, бие болон цүнх сав, авто машинд үзлэг хийх.

**7.2 Хамгаалагч талын үүрэг**

7.2.1. Хамгаалалтын ажилтнуудыг албан ёсоор томилж, тэдэнд гэрээнд заасан ажил үүргийг танилцуулж, тогтвор суурьшилтай ажиллуулах, мэргэжлийн удирдлагаар хангаж байх, дүрэмт хувцас, ялгах тэмдэг, буу, нэг бүрийн тусгай хэрэгсэл, хамгаалалтын бусад нөхцөлөөр хангаж ажиллана.

7.2.2. Радио холбоогоор хамгаалагчдыг хангаж ажиллана.

7.2.3. Харуул хамгаалалтын алба хаагчийг хууль зүйн, бие бялдарын (тусгай мэх, дасгал, тусгай хэрэгсэл хэрэглэх журам) болон бусад шаардлагатай сургалтад хамруулах.

7.2.4. Харуул хамгаалалтын алба хаагчаар 22-55 нас хүрсэн, эрүүл мэнд, бие бялдар, ёс зүйн шаардлага хангасан, зохих боловсрол, ажлын туршлагатай, холбогдох сургалтад хамрагдсан, ял шийтгэлгүй хүнийг ажиллуулна.

7.2.5. Харуул хамгаалалтын алба хаагч нь Гэрээт харуул хамгаалалтын тухай хуулийн 14, 15-р зүйлд заасан эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

7.2.6. Хамгаалалтын найдвартай орчин бүрдүүлэх талаар Үйлчлүүлэгч талд тавьсан шаардлагыг биелүүлээгүйгээс болж үүссэн хохирлыг хамгаалагч тал /түүний алба хаагч/ баримтаар нотолсон тохиолдолд хамаарахгүй.

7.2.7. Хамгаалалтын үйл ажиллагааг тогтмол шалгаж сайжруулна.

7.2.8. Хамгаалалт үйлчилгээтэй холбоотой санал хүсэлт, гомдол шаардлага болон илэрсэн зөрчлийг цаг тухайд нь арилгаж Үйлчлүүлэгч талын удирдлагад мэдэгдэнэ.

7.2.9. Хамгаалалтын алба хаагчдын хариуцлагагүй, буруутай үйл ажиллагаанаас болж Үйлчлүүлэгчид учруулсан хохирол нь баримтаар нотлогдсон тохиолдолд бүрэн төлж барагдуулна.

7.2.10. Ээлжид гарч байгаа хамгаалагчийн ажлын цагийг цаг бүртгэлийн дэвтрээр баталгаажуулна.

7.2.11. Хамгаалалтад авах объект, түүний зааг хязгаар, орон зайг зураглалаар тодорхойлон хүлээн авч, хяналт тавьж ажиллана.

7.2.12. Харуул хамгаалалтын хариуцлагыг өндөржүүлэх зорилгоор улиралд 1-ээс доошгүй удаа харуулын бие бүрэлдэхүүнийг сэлгэн ажилуулж байх.

7.2.13. Хамгаалалтын албаны алба хаагч нар нь объектын дотор болон гадна талын талбай дээр хэв журам сахиулах, гэмт хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх, нэгэнт гарсан хэргийг илрүүлэх, гэмт хэргийн талаар баримт бүрдүүлж цагдаагийн байгууллагад хүлээлгэн өгөх үүрэг хүлээнэ.

7.2.14. Хамгаалагч талын алба хаагч нь хамгаалж байгаа объектоос гарч байгаа зүйлд хяналт тавьж Үйлчлүүлэгч талын эрх бүхий ажилтны зөвшөөрлөөр гаргаж байна.

7.2.15. Хамгаалагч тал нь Үйлчлүүлэгч талын холбогдох дүрэм, журмыг баримталж ажиллана.

7.2.16. Согтууруулах ундаа хэрэглэсэн гадны хүн болон Үйлчлүүлэгч талын ажилтныг хамгаалалтын обьект рүү нэвтрүүлэхийг хориглоно.

7.2.17. Хамгаалагч тал, түүний алба хаагч нь Гэрээт харуул хамгаалалтын тухай Монгол Улсын хуулийн 2-р бүлгийн 9-р зүйлийн 9.1.1-9.1.4-р заалтуудыг биелүүлэх үүргийг Үйлчлүүлэгч талын өмнө хүлээнэ.

## НАЙМ. ХАРУУЛ ХАМГААЛАЛТЫН АЛБА ХААГЧИЙН ЭРХ ҮҮРЭГ

8.1 Хамгаалж байгаа объектод нэвтрэх хүмүүсийн биеийн байцаалтыг шалгаж, зөрчил илэрсэн тохиолдолд Үйлчлүүлэгч болон Хамгаалагч тал болон холбогдох бусад байгууллага албан тушаалтанд мэдэгдэх, хуулийн дагуу шаардлагатай бүх арга хэмжээг авах.

8.2 Хамгаалж байгаа эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулахтай холбогдсон саналыг Үйлчлүүлэгчид амаар болон бичгээр тавих.

8.3 Хамгаалах эд хөрөнгө, объектын бүрэн бүтэн байдал, лац, ломбо, битүүмжлэлийг шалгаж хүлээн авах, хүлээлгэн өгөх, хэрэв эд хөрөнгө, объектын бүрэн бүтэн байдал алдагдсан, лац ломбо хөдөлсөн байвал энэ тухай Үйлчлүүлэгчид болон өөрийн байгууллагын удирдлагад нэн даруй мэдэгдэх.

8.4 Хамгаалж байгаа объектод тэсрэх материал болон бусад зүйлийг оруулж гаргахыг Үйлчлүүлэгчийн эрх бүхий албан тушаалтны зөвшөөрлийн хуудсыг үндэслэн гүйцэтгэх бөгөөд энэ тухай тэмдэглэл хөтлөн бүртгэнэ.

8.5 Хамгаалалтын ажилтан тухайн объектод мөрдөх журмыг хүндэтгэн ажиллаж, үйлчилгээний байгууллагын ёс зүйн хэм хэмжээг сахиж, ажлын цаг эхлэхээс 15 минутын өмнө ажлын байранд ирж, хувийн болон албаны бэлтгэлийг хангана.

8.6 Хамгаалж буй объектын ажилтнуудтай зөв боловсон харьцана.

8.7 Хамгаалалтын албан хаагч нь үүрэг гүйцэтгэж байх хугацаанд болсон үйл явдлыг цаг хугацааны дараалаар дэлгэрэнгүй илтгэж бичнэ.

8.8 Хамгаалж байгаа объектын нийтийн эзэмшлийн гадаад болон дотоод талбайн эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг шалгаж ээлж хүлээлцэнэ.

## ЕС. ГЭНЭТИЙН БОЛОН ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

9.1 Энэ гэрээний зорилгын хүрээнд аль нэг талын боломжит хяналтаас гадуур гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдал /байгалийн гамшиг, ган, зуд, үер, газар хөдлөлт, үйлдвэрлэлийн осол, дайн, төр засгийн эрх бүхий этгээдийн шийдвэрээр хорио цээр тогтоох, гоц халдварт болон цар тахал гарсан, түүнээс болж хөл хорио тогтоосон,/-ын улмаас энэ гэрээний дагуу хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх боломжгүйд хүрэх нөхцөл байдал үүссэнийг гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл гэж ойлгоно.

9.2 Гэнэтийн болон давагдашгүй нөхцөл байдлын улмаас гэрээний дагуу хүлээсэн үүргээ биелүүлж чадаагүй талыг дараах тохиолдолд энэ гэрээг зөрчсөн гэж үзэхгүй. Үүнд: Уг нөхцөл байдалд өртсөн тал нь:

- 9.2.1. Түүнээс урьдчилан сэргийлэх, санал тавих, өөр хувилбар хайх зэргээр гэрээний нөхцөл болзлыг хангахын тулд боломжит бүх арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байх
- 9.2.2. Энэхүү нөхцөл байдал үүссэн талаар нөгөө талдаа аль болох урьдаас урьдчилан мэдэгдсэн байх

9.3. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн нөхцөл байдлын улмаас гэрээний үүргээ биелүүлэх боломжгүй болсон буюу түүнд өртсөн тал нь энэхүү нөхцөл үүссэн тухай нөгөө талдаа бичгээр мэдэгдэнэ.

## АРАВ. ГЭРЭЭНИЙ НУУЦЛАЛ

10.1 Хамгаалагч тал нь гэрээний үүргээ биелүүлэхтэй холбоотойгоор олж авсан аливаа баримт материал, бүхий л мэдээлэл (тухайн ажлыг гүйцэтгэхтэй холбоотой олж авсан мэдээлэл)-ийг бусдад задруулахгүй байх үүрэгтэй ("Нууц Мэдээлэл"). Энэхүү нууцлалыг хуульд заасны дагуу шүүх болон бусад төрийн эрх бүхий байгууллагаас шаардан гаргуулснаас бусад тохиолдолд Үйлчлүүлэгчээс урьдчилсан бичгэн зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдэд задруулахгүй. Энэхүү заалт нь Гэрээний үйлчлэх хугацаанд болон Гэрээ дуусгавар болсон хойно ч мөн адил хүчин төгөлдөр байна.

## АРВАН НЭГ. БУСАД ЗҮЙЛ

11.1. Энэхүү гэрээ нь талуудын эрх бүхий албан тушаалтнууд гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулснаар хүчин төгөлдөр мөрдөгдөнө.

11.2. Гэрээг сунгах тохиолдолд болон гэрээний хэрэгжилтийн явцад гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд гэрээний нэмэлт өөрчлөлт оруулах хэсэгт бичилт хийж, хоёр тал энэхүү гэрээний нэмэлт өөрчлөлт оруулах хэсэгт гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулна.

11.3. Гэрээг аль нэг талын санаачлагаар хугацаанаас өмнө цуцалж болох бөгөөд энэ тохиолдолд гэрээг цуцлах хүсэлтээ гэрээг цуцлах болсон үндэслэлийн хамт нэг сарын өмнө нөгөө талдаа албан бичгээр мэдэгдэнэ. Гэрээг нэг талын буруутай үйлдлийн улмаас цуцалсан тохиолдолд гэм буруутай тал нь ийнхүү гэрээ цуцалсны улмаас нөгөө талд учирсан хохирлыг нөхөн төлнө.

11.4. Гэрээний хугацаа дуусгавар болсон, эсхүл гэрээг хугацаанаас нь өмнө цуцалсан нь гэрээний аль нэг тал нь нөгөө талын өмнө хүлээсэн эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус үүргээ биелүүлэх, хохирол, зардлыг хариуцан арилгах үүргээс татгалзах, нөхөн төлөхгүй байх үндэслэл болохгүй.

11.5. Энэхүү гэрээтэй холбогдон гарч болох бүхий л санал зөрөлдөөн, маргааныг талууд харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэхийг эрмэлзэнэ. Харилцан зөвшилцөлд хүрээгүй тохиолдолд Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

11.6. Талууд энэхүү гэрээнд заасан аливаа нөхцлийг урьдчилан гүйцэд уншиж танилцсан, гэрээний талаарх бүрэн мэдээлэл, ойлголтыг авсан бөгөөд Талууд сайн дурын үндсэн дээр энэхүү гэрээг байгуулж байгаа, гэрээ байгуулах үеэр эрх зүйн бүрэн чадамжтай байсан болно.

### ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

| ХАМГААЛАГЧ ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ: | ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ: |
|---|---|
| "АЗИЙН ТОП ЭХЛЭЛ" ХХК-ийн | "ҮНЭН АНД" ХХК-ийн |
| Харуул хамгаалалтын албаны дарга | Захирал |
| ............................ /Н.Мөнхдэлгэр/ | ...................................../Т.Төмөрсоль/ |
| Утас: 77137777, 99176174 | Утас: 88114980 |
| Мэйл хаяг: Aziintop.mn@yahoo.com | Мэйл хаяг: |

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

**ХАРУУЛ ХАМГААЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН**

# ГЭРЧИЛГЭЭ

**Дугаар 202307000043**

Зөвшөөрлийн тухай хуулийн 5.5 дугаар зүйлийн 14 дэх хэсэг, 8.1 дүгээр зүйлийн 11.6 дахь заалт, Гэрээт харуул хамгаалалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн А/101 дугаар тушаалаар "Азийн топ эхлэл" ХХК (Улсын бүртгэлийн дугаар:9011371004, Регистрийн дугаар:5633362, Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 3-р хороо Энхтайваны өргөн чөлөө ВИП оффис 501 тоотод байрлах)-ийн харуул хамгаалалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг таван жилийн хугацаагаар сунгав.

**ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА** **П.САЙНЗОРИГ**

**2023 оны 05 дугаар сарын 17 -ны өдөр**

**МОНГОЛ УЛС**
**УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ**

# АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

2022 оны 12 сарын 23 өдөр    Дугаар 862    Улаанбаатар хот

| | |
|---|---|
| *Эрхлэх үйл ажиллагааны төрөл* | Үйлдвэрлэлийн зориулалттай тэсэлгээний ажил явуулах |
| *Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр* | "ҮНЭН АНД" ХХК |
| *Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хаяг* | Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Ерөнхий сайд Амарын гудамж, Соёлын төв өргөө, 902 тоот |
| *Регистрийн дугаар* | 2885565 |
| *Тусгай зөвшөөрлийн хугацаа* | 5 /Тав/ жил |
| *Тусгай нөхцөл, шаардлага* | Холбогдох хууль, журам, дүрэмд заасан бүх шаардлагыг хангаж ажиллах |

*Монгол Улсын Уул уурхай, хүнд үйлдвэрийн Сайдын 2022 оны 12 сарын 23 өдрийн А/314 дугаар тушаалыг үндэслэн олгов.*

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН,
ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН,
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙД    Ж.ГАНБААТАР

**БАТЛАВ:**
**Даатгагчийг төлөөлж:**
"НОМИН ДААТГАЛ" ХХК-ийн
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
С.ГАНБААТАР

**БАТЛАВ:**
**Даатгуулагчийг төлөөлж:**
"ҮНЭН-АНД" ХХК-ийн
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Т.ТӨМӨРСОЛЬ

# ГЭНЭТИЙН ОСЛЫН ДААТГАЛЫН ГЭРЭЭ

**№: 240411-5398**

2024-04-29 өдөр

Улаанбаатар хот

Нэг талаас "ҮНЭН-АНД" ХХК 2885565 регистрийн дугаартай /цаашид "Даатгуулагч" гэх/, нөгөө талаас "НОМИН ДААТГАЛ ХХК" 2679698 регистрийн дугаартай /цаашид "Даатгагч" гэх/ нар /цаашид хамтад нь талууд гэх/ харилцан тохиролцсоны үндсэн дээр МУ-ын Иргэний хуулийн 43 дугаар бүлэг, Даатгалын тухай хуулийг удирдлага болгон дараах нөхцөлтэйгөөр энэхүү гэрээг байгуулав.

## Нэг. Ерөнхий зүйл

1.1 Энэхүү гэрээгээр даатгагч нь Монгол Улсын нутаг дэвсгэрт тохиолдсон даатгалын эрсдэлийн улмаас даатгалын тохиолдол болсон нөхцөлд нөхөн төлбөрийг төлөх, даатгуулагч нь даатгагчид даатгалын хураамж төлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

1.2 Даатгалын хугацаанд даатгагчийн хүлээх хариуцлага нь даатгалын зүйл тус бүр дээр тухайн зүйл тус бүрийн даатгалын үнэлгээнээс хэтрэхгүй байна.

1.3 Талууд гэрээг харилцан зөвшөөрч, гарын үсэг зурж, тамга тэмдэг дарж баталгаажуулсан, даатгалын хураамж төлөгдсөн байх нөхцөлүүд зэрэг хангагдсан өдрөөс гэрээ хүчин төгөлдөр үйлчилж эхлэнэ.

1.4 Даатгуулагчийн даатгуулахаар бүрдүүлж өгсөн материалууд, мэдүүлэг нь гэрээний хавсралт буюу гэрээний үндэс болно.

1.5 Энэхүү гэрээнд даатгалын үнэлгээ, даатгалын хураамжийг заавал бичнэ.

1.6 Талууд энэхүү гэрээнд хэрэглэгдэх үгсийг дор дурдсан утгаар ойлгох бөгөөд даатгалын баталгаанд ижил утгаар хэрэглэгдэх болно. Үүнд:

- 1.6.1 **Даатгагч** – Даатгуулагчийн ашиг сонирхлын дагуу даатгалын зүйлийг даатгаж гэрээ байгуулсан, Даатгалын тухай Монгол Улсын хуулийн дагуу даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан НОМИН ДААТГАЛ ХХК-ийг;
- 1.6.2 **Даатгуулагч** - Өөрийн ашиг сонирхлын төлөө даатгалын зүйлээ даатгуулж, даатгагчтай гэрээ байгуулсан иргэн, хуулийн этгээдийг /Даатгуулагч хуулийн этгээд байх тохиолдолд түүний ажилтнууд хамаарна/;
- 1.6.3 **Даатгалын зүйл** - Даатгалын гэрээ болон баталгаанд заагдсан иргэний амь нас эрүүл мэндийг;
- 1.6.4 **Даатгалын мэдүүлэг** - Даатгалын зүйлийг тодорхойлж байгаа төрөл бүрийн баримт материал, мэдээллийг;
- 1.6.5 **Даатгалын баталгаа** - Даатгуулагчийн даатгуулсныг баталгаажуулж, гэрээнд хавсарган даатгуулагчид олгох баталгаа бичгийг;
- 1.6.6 **Даатгалын үнэлгээ** - Даатгалын зүйлийн зах зээлийн үнийг үндэслэн даатгагч, даатгуулагч нар харилцан тохиролцсон үнийг;
- 1.6.7 **Даатгалын хураамж** - Даатгуулагч даатгалын зүйлээ даатгуулсны төлөө даатгагчид төлөх төлбөрийг;
- 1.6.8 **Даатгалын тохиолдол** - Даатгалын зүйлд даатгалын эрсдэлийн улмаас хохирол учрах, гэрээгээр тохиролцсон болзол бүрдэхийг;
- 1.6.9 **Нөхөн төлбөр** - Гэрээнд заасан даатгалын тохиолдол үүссэн нөхцөлд даатгагчаас гэрээний дагуу даатгуулагчид учирсан хохирлыг буцаан төлөх;
- 1.6.10 **Нөхөн төлбөр олгохгүй нөхцөлүүд** - Даатгагч нөхөн төлбөр олгохгүйгээр гэрээнд заасан нөхцөлүүдийг;
- 1.6.11 **Гэнэтийн осол** –Үйлдвэрлэлийн болон ахуйн осолд хамаарах гэнэтийн санамсаргүй тохиолдол, болгоомжгүй үйлдлийн улмаас даатгуулагчийн амь нас эрүүл мэндэд хохирол учрах;
- 1.6.12 **Хөдөлмөрийн чадвар бүрэн алдалт** - Хөдөлмөрийн чадвараа 70 буюу түүнээс дээш хувиар алдахыг;
- 1.6.13 **Хөдөлмөрийн чадвар хагас алдалт** - Хөдөлмөрийн чадвараа 50-69 хувиар алдахыг;

1.6.14 **Хөдөлмөрийн чадварын түр алдалт -** Хөдөлмөрийн чадвараа 90 хүртэл хоногийн хугацаанд түр алдаж эмнэлэг, амбулатори, гэрээр эмчлүүлэхийг;

1.6.15 **Спортын аюултай төрлүүд -** Уралдааны машин, мотоцикл, морь, дугуйны уралдаанд бэлтгэх, оролцох, сонирхогчийн болон дельта нислэг, шухэр, бие хамгаалах бүх төрлийн спорт;

**Хоёр. Гэрээний хугацаа**

2.1 Даатгалын гэрээ 2024 оны 04-р сарын 29-ны өдрөөс эхлэн 2024оны 11-р сарын 30-ны өдөр хүртэл 7 сарын хугацаанд хүчинтэй байна.

2.2 Даатгалын гэрээ дараах тохиолдолд дуусгавар болно. Үүнд:

2.2.1 Хууль, гэрээгээр тогтоосон хугацаа дуусгавар болсон;

2.2.2 Шүүх гэрээг хүчин төгөлдөр бус гэж тооцсон;

2.2.3 Талууд тохиролцож гэрээг цуцалсан;

2.2.4 Даатгагч гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлсэн;

2.3 Гэрээний хугацаа дуусахаас 14 хоногийн өмнө талууд гэрээний хугацааг сунгах тухай хүсэлтээ албан ёсоор мэдэгдэж гэрээг шинээр байгуулах бөгөөд даатгалын баталгааг шинэчилнэ.

**Гурав. Даатгалын зүйл**

3.1 Даатгалын гэрээнд заагдсан "Үнэн-Анд" ХХК - ны Дундговь аймагийн баянжаргалан сумын 2-р баг нутагт байрлах жоншны уурхайн хөдөлмөрийн гэрээтэй хятад, монгол ажилчдын амь нас, эрүүл мэнд нь даатгалын зүйл болно.

**Дөрөв. Даатгалын эрсдэл**

4.1 Байгалийн /газар хөдлөлт, цасан болон шороон шуурга, хүчит салхи, үер, хөрсний нуралт, цөмрөлт, аянга, аадар бороо, мөндөр, ой хээрийн түймэр, усанд живэх, шавар намагт шигдэх зэрэг/ эрсдэл

4.2 Хордлогод орох /нарны, хоолны, химийн зэрэг/ эрсдэл

4.3 Ахуйн /унаж бэртэх, халтирах, зам тээврийн аюул осолд өртөх, элдэв юманд цохиулах, хавчуулах, түлэгдэх, хорт хийнд хордох зэрэг/ эрсдэл

4.4 Үйлдвэрлэл техникийн /машин тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлтэй харьцах үед болон цахилгаан хүчдэл, дэлбэрэлт, шаталт зэргийн нөлөөгөөр учирсан осол, химийн бодист хордох, аюулгүй ажиллагааны дүрэм зөрчигдсөнөөс гарч болох осол зэрэг/ эрсдэл

4.5 Техниктэй харьцах үеийн /унадаг дугуй, мотоцикл, автомашин зэрэг авто болон механик тээврийн хэрэгсэл, төмөр зам, агаарын болон усан замын тээврийн хэрэгслээр зорчих явцад тухайн тээврийн хэрэгсэл онхолдох, мөргөлдөх, унах, живэх зэрэг/ эрсдэл

4.6 Мал амьтдын нөлөөгөөр үүсэх /малд дайруулах, мөргүүлэх, өшиглүүлэх, тийрүүлэх, хазуулах тэрчлэн араатан амьтад, нохойд бариулах, морь малаас унах зэрэг /эрсдэл

4.7 Гадны нөлөөллийн /бусдын гэмт үйлдлийн улмаас сум, хутга мэсэнд өртөх, хорлогдох, зодуулах, цохиулах зэргээр гэмтэх/ эрсдэл

**Тав. Даатгалын үнэлгээ, даатгалын хураамж**

5.1 Даатгуулагч нь даатгалын үнэлгээг нэг ажилтны хувьд 500'000'000 /таван зуун сая / төгрөгөөр, 8 ажилтны даатгалын нийт үнэлгээг 4'000'000'000 /дөрвөн тэрбум / төгрөгөөр харилцан тохиролцож тогтоов.

5.2 Даатгалын хураамжийг даатгалын нийт үнэлгээнээс 0.65%-аар тооцож нийт 8 ажилтны 26'000'000 / хорин зургаан сая/ төгрөг төлөхөөр харилцан тохиролцов.

5.3 Даатгалын хураамжийг гэрээ байгуулсан даруй даатгагчид төлнө.

5.4 Даатгалын гэрээний хамгаалалт даатгалын хураамж төлөгдсөн өдөр, цагаас эхлэн үйлчлэх бөгөөд хэрэв хураамж төлөгдөөгүй байх хугацаанд даатгалын тохиолдол үүссэн бол даатгалын зүйлд учирсан хохирлыг даатгагч хариуцахгүй.

**Зургаа. Нөхөн төлбөр**

6.1 Даатгагч гэрээний 7 дугаар зүйлд заасан даатгалд хамрагдахгүй нөхцөлүүд хэсэгт заагдсанаас бусад тохиолдолд буюу даатгалын эрсдэлийн улмаас даатгуулагчид учирсан хохирлын нийт зардлыг даатгалын үнэлгээнд багтаан нөхөн төлнө.

6.2 Даатгуулагч нас барсан эсвэл хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан тохиолдолд даатгалын үнэлгээг 100%-аар олгоно.

6.3 Хөдөлмөрийн чадвараа хагас болон түр алдсан тохиолдолд Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын дүгнэлт, мэргэжлийн эмчийн дүгнэлтээр даатгуулагчийн эмнэлэг, амбулатори, гэрээр эмчлүүлэхэд гарсан эмчилгээний зардлыг үндэслэн даатгалын үнэлгээнд багтаан нөхөн төлбөрийг олгоно.

6.4 Даатгуулагч гэнэтийн ослын улмаас гэмтэж бэртэн даатгалын нөхөн төлбөр авсны дараа даатгалын хугацаанд уг гэмтлийн үр дагаврыг дахин эмчлүүлсэн, нөхөн сэргээх эмчилгээ хийлгэсэн тохиолдолд гарсан эмчилгээний зардлыг даатгалын үнэлгээнээс эмчилгээний зардлыг хассан үлдэгдэл үнэлгээнд багтаан нэг удаа 100% нөхөн төлнө.

6.5 Даатгагч нөхөн төлбөрийн нэхэмжлэл болон бусад баримт материалыг Даатгуулагчаас бүрэн хүлээн авч шаардлага хангасан гэж үзвэл материал бүрэн бүрдүүлж өгснөөс хойш ажлын 14 хоногийн дотор нөхөн төлбөр олгох эсэхийг шийдвэрлэнэ.

6.6 Хэрэв Даатгагч нөхөн төлбөрийг хууль болон энэхүү гэрээнд заасан үндэслэлээр бүрэн болон зарим хэсгийг олгохоос татгалзаж шийдвэрлэсэн бол энэ тухайгаа Даатгуулагчид бичгээр мэдэгдэнэ.

6.7 Даатгалын тохиолдол нь хуулийн байгууллагаар үргэлжлүүлэн шалгагдаж байгаа нөхцөлд нөхөн төлбөр шийдвэрлэх хугацааг сунгаж болно.

6.8 Даатгагч даатгалын гэрээнд заасан хугацаанд даатгалын нөхөн төлбөр олгоогүй бол Иргэний хуулийн 232.6-д заасны дагуу хоног тутамд гүйцэтгээгүй үнийн дүнгийн 0.5 хувиар алданги тооцон даатгуулагчид олгоно.

6.9 Даатгуулагч нөхөн төлбөрийг нэхэмжлэхдээ дараах материалыг бүрдүүлнэ. Үүнд:
   6.9.1 Хохирол нөхөн төлүүлэх тухай даатгуулагчийн өргөдөл, албан бичиг;
   6.9.2 Даатгалын гэрээ, даатгалын баталгаа;
   6.9.3 Цагдаагийн байгууллага, Онцгой байдлын газар, Шүүх, Прокурор, Эмнэлгийн байгууллагын дүгнэлт, тодорхойлолт, эмчлүүлсэн магадалгаа, эмчилгээнд гарсан зардлын баримт, эмчилгээний тухай бичилт хийсэн амбулаторийн карт, эмнэлгийн хуудас зэрэг баримт бичиг;
   6.9.4 Учирсан хохиролд холбоотой хариуцагчийн өргөдөл, тодорхойлолт болон бусад мэдээллүүд, шаардагдах бусад бичиг баримт;

6.10 Даатгагч дараах үндэслэлээр нөхөн төлбөрийг бүрэн буюу зарим хэсгийг олгохоос татгалзаж болно: Үүнд:
   6.10.1 Даатгуулагч санаатайгаар хохирол учруулсан буюу даатгалын тохиолдол бий болох нөхцөл орчныг бүрдүүлсэн;
   6.10.2 Даатгуулагч эсвэл түүний төлөөлөгч даатгалын зүйлийн талаар даатгагчид худал мэдээлсэн, хуурамч бичиг баримт бүрдүүлсэн нь тогтоогдсон;
   6.10.3 Учирсан хохирлыг даатгуулагч буруутай этгээдээр нөхөн төлүүлсэн;
   6.10.4 Хууль тогтоомжид заасан бусад үндэслэл;

## Долоо. Нөхөн төлбөр олгохгүй нөхцөлүүд

7.1 Талууд гэрээг харилцан зөвшөөрч, гарын үсэг зурж, тамга тэмдэг дарж баталгаажуулсан, даатгалын хураамж төлөгдсөн байх нөхцөлүүд зэрэг хангагдаагүй;

7.2 Осол гэмтлийн бус шалтгаантай өвчин эмгэгийн улмаас эмчилгээ хийлгэсэн;

7.3 Гэрээний хугацаа эхлэхээс өмнө эсвэл хугацаа дууссаны дараа учирсан эрсдэлийн улмаас гарсан эмчилгээний зардал;

7.4 Гэнэтийн ослоос бусад шалтгаанаар зулбах, дутуу төрөх болон төрөх үеийн хүндрэл, ургийн үеийн мэс ажилбар, үр хөндүүлэх зэрэгтэй холбоотой эмчилгээ;

7.5 Санаатайгаар өөрийн биед гэмтэл учруулсан, гэмтэл учруулахыг завдсан, амиа хорлосон, амиа хорлохыг завдсан зэргээс үүссэн гэмтэл, бэртэл;

7.6 Спортын аюултай төрлүүдээр хичээллэх, тухайн төрлийн уралдаан тэмцээнд оролцож гэмтэж бэртсэн;

7.7 Согтууруулах ундаа, мансууруулах эсвэл сэргээх үйлчилгээтэй бодис хэрэглэсний улмаас учирсан хохирол;

7.8 Холбогдох мэргэжлийн байгууллагад учирсан хохирлын талаар газар дээр нь мэдэгдэж үзлэг шалгалт хийлгэн акт дүгнэлт гаргуулаагүй, гэрээнд заасан хугацаанд даатгагчид мэдэгдэж, хохиролтой холбоотой материалыг даатгагчид ирүүлээгүй;

7.9 Залилан мэхлэх замаар эмнэлгийн акт, магадалгаа гаргуулан авсан болон хуурамчаар үйлдсэн нь нотлогдсон;

7.10 Даатгуулагч хууль бус, эрүүгийн шинж чанартай гэмт хэрэг үйлдсэн болон үйлдэхийг завдсаны улмаас учирсан хохирол;

7.11 Цацраг идэвхт бодисын хордлого, бохирдолт зэргээс үүссэн өвчин, эмгэг, бие махбодын гэмтэл, тэдгээрийн үр дагавар мөн цөмийн зэвсгийн холбогдолтой материалуудаас үүссэн хохирол;

7.12 Дайн байлдаан, үймээн самуун, бослого, ажил хаялт, улс төрийн болон террорист үйл ажиллагааны үр дагавар;

## Найм. Даатгуулагчийн эрх, үүрэг

8.1 Даатгуулагч дараах эрхийг эдэлнэ. Үүнд:
   8.1.1 Даатгуулагч даатгалын тохиолдол болсон үед гэрээний нөхцөлийн дагуу нөхөн төлбөр олгохыг Даатгагчаас шаардах;
   8.1.2 Даатгагч хууль болон гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд гэрээг цуцлах эсвэл түүнд өөрчлөлт оруулахыг шаардах;
8.2 Даатгуулагч дараах үүргийг хүлээнэ. Үүнд:
   8.2.1 Даатгалын хураамжийг гэрээнд заасан хувь хэмжээгээр, гэрээгээр тохирсон хугацаанд төлөх;
   8.2.2 Аливаа хохирол гарахаас урьдчилан сэргийлэх, зайлшгүй мөрдөх ёстой хөдөлмөр хамгааллын болон техник аюулгүй ажиллагааны дүрэм зааврыг дагаж мөрдөх, гарсан хохирлын хэмжээг бууруулах бүхий л боломжит арга хэмжээг авсан байх;
   8.2.3 Даатгуулагч гэрээгээр хүлээх үүрэг, өөрийн зүгээс хийвэл зохих зүйлсийн талаарх даатгалын гэрээний нөхцөлүүдийг сайтар судалж мэдсэн байх, даатгагчийг үнэн зөв мэдээллээр хангах;
   8.2.4 Даатгуулагч даатгалын тохиолдлыг даатгагчид хот дотор 24 цаг, хөдөө орон нутагт 72 цагийн дотор 89887701, 89887702, 89887703, 89887704, 89887751, 89887752, 75775555 утсаар мэдэгдэж, хохирол гарсан тухай дэлгэрэнгүй тайланг нотлох баримт, материалуудын хамт хуанлийн 45 хоногийн дотор даатгагчийн хаягаар ирүүлэх;
   8.2.5 Даатгуулагч зайлшгүй тохиолдлоор дээрх хугацаанд багтаан материалуудыг ирүүлэх боломжгүй бол энэ тухай даатгагчид бичгээр мэдэгдэх;
   8.2.6 Энэхүү гэрээнд заасны дагуу даатгагчаас гарсан зардлыг буруутай этгээдээс нэхэмжлэн авахад даатгуулагч бүхий л талын туслалцааг үзүүлэх;
   8.2.7 Хохирлын хэмжээг үнэн зөв тогтоох зорилгоор даатгагчтай бүх талаар идэвхтэй хамтран ажиллах;
8.3 Хууль болон гэрээнд заасан бусад эрх үүрэг

## Ес. Даатгагчийн эрх, үүрэг

9.1 Даатгагч дараах эрхийг эдэлнэ. Үүнд:
   9.1.1 Даатгуулагч МУ-ын Иргэний хууль болон Даатгалын тухай хуулийн холбогдох заалтуудаар хүлээсэн үүрэг болон гэрээний наймдугаар бүлэгт заагдсан үүргээ биелүүлээгүй тохиолдолд даатгагч нөхөн төлбөрийг бүрэн буюу хэсэгчлэн олгохоос татгалзах;
   9.1.2 Даатгуулагч хууль болон гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд гэрээг цуцлах эсвэл түүнд өөрчлөлт оруулахыг шаардах;
   9.1.3 Шаардлагатай тохиолдолд даатгалын тохиолдол болсон үед түүний шалтгаан, нөхцөлийг судлах, эрх бүхий байгууллагаар шалгуулах, шаардлагатай нэмэлт мэдээ, мэдээллийг даатгуулагчаас гаргуулж авах;
   9.1.4 Даатгагч даатгуулагчид учирсан хохирлыг нөхөн барагдуулсны дараа буруутай этгээдээс даатгалаар олгогдсон нөхөн төлбөр, түүнтэй холбогдон гарсан зардлыг нэхэмжлэх;
   9.1.5 Буруутай этгээдээс хохирлыг нэхэмжлэн авах даатгагчийн эрхийг даатгуулагчийн зүгээс ямар нэгэн хэлбэрээр хязгаарласан эсвэл багасгасан тохиолдолд даатгагч даатгуулагчийн нөхөн төлбөрийн дүнгээс хасах замаар энэ алдагдлаа нөхөж авах;
9.2 Даатгагч дараах үүргийг хүлээнэ. Үүнд:
   9.2.1 Даатгалын гэрээний нөхцөлийг даатгуулагчид танилцуулах;
   9.2.2 Даатгагч даатгуулагчийн даатгалтай хугацаанд гэрээнд заасан нөхцөлийн дагуу даатгалаар хангах;
   9.2.3 Даатгалын тохиолдол болсон үед нөхөн төлбөрийг хууль болон гэрээгээр тохиролцсон хугацаа хэмжээнд олгох;
9.3 Хууль болон гэрээнд заасан бусад эрх үүрэг

## Арав. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, цуцлах

10.1 Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд энэ тухай саналаа нөгөө талдаа 14 хоногийн өмнө бичгээр мэдэгдэнэ.
10.2 Нэмэлт өөрчлөлт оруулсан тохиолдолд талууд гарын үсэг зурж, тамга дарж баталгаажуулан үндсэн гэрээнд хавсаргах ба тэрхүү нэмэлт, өөрчлөлт нь энэхүү гэрээний салшгүй хэсэг байна.

10.3 Дараах үндэслэлээр Даатгагчийн санаачилгаар гэрээг цуцална. Үүнд:

10.3.1 Даатгуулагч даатгалын тохиолдлыг санаатайгаар бий болгох оролдлого хийсэн, санаатайгаар бий болгосон.

10.3.2 Даатгуулагч Даатгагчийн зүгээс нөхөн төлбөрийг тодорхойлох зорилгоор шаардсан баримт материалыг гаргаж өгөхөөс үндэслэлгүйгээр татгалзсан.

10.3.3 Даатгуулагч даатгалын тохиолдлыг нотлох баримтыг хуурамчаар бүрдүүлсэн нь тогтоогдсон.

10.3.4 Даатгалын нөхөн төлбөр олгогдсоны дараа буруутай этгээдээс хохирлыг нэхэмжлэн авах даатгагчийн эрхийг даатгуулагчийн зүгээс ямар нэгэн хэлбэрээр хязгаарласан, буруутай этгээдээс хохирол нэхэмжлэхэд шаардлагатай материалыг Даатгуулагчийн зүгээс Даатгагчид гаргаж өгөх болон туслалцаа үзүүлэхээс үндэслэлгүйгээр татгалзсан.

10.4 Дараах үндэслэлээр Даатгуулагчийн санаачилгаар гэрээг цуцална.

10.4.1 Даатгалын тохиолдол болоход Даатгагчийн зүгээс хууль болон гэрээнд зааснаас бусад шалтгаанаар даатгалын нөхөн төлбөр олгохоос үндэслэлгүйгээр татгалзсан.

10.4.2 Даатгалын нөхөн төлбөр олгох гэрээнд заасан хугацааг 30-аас дээш хоногоор хэтрүүлсэн.

10.5 Даатгалын гэрээг талуудын аль нэгний санаачилгаар хугацаанаас өмнө цуцлахад хүрвэл гэрээний үлдсэн хугацаанд ногдох даатгалын хураамжаас даатгуулагчийн авсан нөхөн төлбөр, тухайн даатгалтай холбогдон гарсан бодит зардлыг хасаж үлдэх хэсгийг даатгуулагчид буцаан олгоно.

10.6 Талуудын аль нэг нь гэрээг цуцлах санал гаргавал нөгөө талдаа ажлын 10 хоногийн өмнө бичгээр мэдэгдэнэ.

10.7 Гэрээг цуцлах санал хүлээн авсан тал нь хариуг ажлын 3 хоногийн дотор ирүүлээгүй бол гэрээний 10.6-д заасан хугацаа өнгөрснөөр гэрээг цуцлагдсанд тооцно.

### Арван нэг. Маргаан шийдвэрлэх

11.1 Энэхүү гэрээг хэрэгжүүлэх явцад үүссэн аливаа маргаантай асуудлыг талууд харилцан зөвшилцөж шийдвэрлэх ба хэрэв эв зүйгээр шийдвэрлэх боломжгүй нөхцөлд Санхүүгийн Зохицуулах Хороонд хандаж шийдвэрлүүлнэ.

11.2 Санхүүгийн Зохицуулах Хорооны шийдвэрийг аль нэг тал эс зөвшөөрвөл холбогдох хуулийн дагуу шүүхэд хандана.

### Арван хоёр. Гэрээний нууцлал

12.1 Энэхүү гэрээ нь байгууллагын нууцад хамаарах тул талууд бусад этгээдэд тараах, дамжуулах, хэвлэн тараах, нийтийн хүртээл болгохыг хориглоно.

12.2 Тус шаардлагыг биелүүлээгүй талд хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх болно.

### Арван гурав. Бусад зүйл

13.1 Энэхүү гэрээг адил хүчинтэй 2 хувь үйлдэж, талууд тус бүр 1 хувийг тус тус хадгална.

13.2 Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн үйлчлэлийн улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон бол талууд хариуцлагаас чөлөөлөгдөх ба дээрх нөхцөл байдал үүссэн талаар нөгөө талдаа нэн даруй мэдэгдэнэ. Ийнхүү мэдэгдээгүй буюу баримтаар нотлоогүй тохиолдолд хариуцлагаас чөлөөлөгдөхгүй.

13.3 Санхүүгийн Зохицуулах Хорооны шийдвэрийг аль нэг тал эс зөвшөөрвөл шүүхэд гомдол гаргаж болно.

13.4 Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн үйлчлэл (Байгалийн гамшигт үзэгдэл, төрийн эрх бүхий байгууллагын хязгаарлалт, хорио цээрийн дэглэм, дайн байлдаан, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал зэрэг хамаарна)- ийн улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон бол талууд хариуцлагаас чөлөөлөгдөх ба дээрх нөхцөл байдал үүссэн талаар нөгөө талдаа нэн даруй мэдэгдэнэ. Ийнхүү мэдэгдээгүй буюу баримтаар нотлогдоогүй тохиолдолд хариуцлагаас чөлөөлөгдөхгүй.

**Гэрээ байгуулсан:**

| | |
|---|---|
| **Даатгагчийг төлөөлж:** | **Даатгуулагчийг төлөөлж:** |
| Э.Бат-Эрдэнэ | Түмэнзаяа |

**Талуудын албан ёсны хаяг**

| | |
|---|---|
| **Даатгагчийн хаяг** | **Даатгуулагчийн хаяг** |

Монгол улс, Улаанбаатар хот 17042
210136, Хан-Уул дүүрэг
Чингисийн өргөн чөлөө
Номин Юнайтед
Шуудангийн хайрцаг 2316
Утас: 1800-2888
Факс: 75775555
Э-мэйл: insurance@nomin.net

Монгол улс,Улаанбаатар хот
Сүхбаатар дүүрэг,8-р хороо
Ерөнхий сайд Амарын гудамж
СТӨ-ний 902
утас:99132080
Факс:330104
Е-мэйл: tumursoli@yahoo.com

МИГ ДААТГАЛ

МОНГОЛ УЛС, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, 13-р хороолол, Олимпийн гудамж, Дугаар 39, G center, 3,4 давхарт
Утас:+976-75756000
Э-Шуудан: info@mig.mn

МИГ ДААТГАЛ ХХК
УЛААНБААТАР 6 САЛБАР
Сүхбаатар дүүргийн 3-р хороо, 5 хороолол, Ус-3 41 тоот
Утас : +7010 7100
Ц/шуудан : ub6@mig.mn
Ц/хуудас: www.mig.mn

# БАЙГУУЛЛАГЫН ЕРӨНХИЙ ХАРИУЦЛАГЫН ДААТГАЛЫН ГЭРЭЭ

# № D24155004

**БАТЛАВ:**

| | |
|---|---|
| **Даатгагчийн төлөөлж:** | **Даатгуулагчийг төлөөлж:** |
| **“МИГ ДААТГАЛ” ХХК-ИЙН САЛБАРЫН ЗАХИРАЛ Б.МӨНГӨНЦӨГЦ** | **“ҮНЭН АНД” ХХК-ИЙН ЗАХИРАЛ Т.ТӨМӨРСОЛЬ** |
| /........................../ | /........................../ |

**МИГ ДААТГАЛ**

## ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

2024 оны 04-р сарын 15-ны өдөр | Дугаар D24155004 | Улаанбаатар хот

| | |
|---|---|
| **ДААТГАЛЫН ХЭЛБЭР:** | Байгууллагын Ерөнхий Хариуцлагын Даатгал |
| **ДААТГАГЧ:** | "МИГ ДААТГАЛ" ХХК |
| **ДААТГУУЛАГЧ:** | "ҮНЭН АНД" ХХК |
| **ДААТГУУЛАГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА:** | ................................................................ |
| **ХАЯГ, БАЙРШИЛ:** | МОНГОЛ УЛС, Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг 2-р хороо 5-р хороолол 32-96 тоот Утас: 88114980 |
| **ДААТГАЛЫН ЗҮЙЛ:** | Даатгалын гэрээнд заасан даатгуулагч, байгууллагын орчин дахь өдөр тутмын, энгийн үйл ажиллагааны улмаас гуравдагч этгээдийн амь нас, эрүүл мэнд болон эд хөрөнгөд учирсан хохиролд хүлээх хуулийн хариуцлага. /Байгууллагад ажиллаж байгаа мэргэжлийн үнэмлэх, тусгай зөвшөөрөл бүхий ажиллагсдын мэргэжлийн үйл ажиллагааны улмаас үүдсэн хариуцлага биш болно. / |
| **ДААТГАЛЫН ХАМГААЛАЛТ:** | Гэрээнд заагдсан эрсдэлээс хамгаална. |
| **ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА:** | 2024 оны 04 сарын 15-ний өдрөөс 2025 оны 04 сарын 14-ний өдрийн 24:00 цаг хүртэл хүчин төгөлдөр байна. |
| **ДААТГАЛЫН ҮНЭЛГЭЭ:** | 20 000 000 төгрөг |
| **ДААТГАЛЫН ХУРААМЖ:** | Хураамжийн хувь: 1%<br>Хураамжийн дүн: 200 000₮ |
| **ХАРИУЦЛАГЫН ХЯЗГААР:** | Нийт хариуцлагын хязгаар 20 000 000 ₮<br>Нэг удаагийн тохиолдлын хариуцлагын хязгаар<br>a.Гуравдагч этгээдийн амь нас, эрүүл мэндэд учирсан хохиролд 10 000 000₮ /хүн тус бүр/<br>b.Гуравдагч этгээдийн эд хөрөнгийн хохиролд 10 000 000 ₮/нэг удаагийн тохиолдолд / |
| **ДААТГУУЛАГЧИЙН ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА:** | Даатгуулагч өөрийн хүлээх хариуцлагын хэмжээ 20 хувь байна. |
| **ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ:** | Монгол Улсын холбогдох хууль, дүрэм журмыг Баримтална. |
| **ГАЗАР НУТГИЙН ХЯЗГААР:** | Монгол Улс |
| **НЭМЭЛТ ХАМГААЛАЛТ:** | байхгүй |
| **ТУСГАЙ ХАСАЛТ:** | байхгүй |
| **ГЭРЭЭНИЙ ҮНДСЭН НӨХЦӨЛД ОРСОН ӨӨРЧЛӨЛТҮҮД:** | байхгүй |

## НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1. Энэхүү даатгалын гэрээгээр (цаашид "Гэрээ" гэх) Даатгуулагч Гэрээнд заасан даатгалын зүйлээ даатгуулж хураамж төлөх, Даатгагч нь даатгалын тохиолдол учирсан үед гарсан хохирлыг Гэрээнд заасан нөхцөлийн дагуу нөхөн төлөхтэй холбоотой харилцааг зохицуулна.

1.2. Байгууллагын ерөнхий хариуцлагын даатгалын гэрээ нь гэрээний тусгай нөхцөл, үндсэн нөхцөл болон гэрээний хавсралтуудаас бүрдэнэ.

1.3. Гэрээний тусгай нөхцөлд Байгууллагын ерөнхий хариуцлагын даатгалын гэрээний үндсэн нөхцөлоос өөрөөр заасан бол тусгай нөхцөлийн заалтыг дагаж мөрдөнө.

1.4. Даатгагч, Даатгуулагч талууд (цаашид хамтад нь "Талууд" гэх) Гэрээг хэрэгжүүлэхдээ Монгол улсын үндсэн хууль, Иргэний хууль, Даатгалын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.

1.5. Гэрээг Монгол болон гадаад хэл дээр үйлдсэн нөхцөлд Монгол хэл дээрхи гэрээг давуу эрхтэй хэрэглэнэ.

1.6. Гэрээнд өөрөөр заагаагүй бол энэхүү даатгалын үйлчлэх хүрээ нь Монгол улсын нутаг дэвсгэр байна.

## ХОЁР. НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

2.1 Гэрээнд дурьдагдсан дараах нэр томъёог дор дурьдсан утгаар ойлгоно. Үүнд:

2.1.1 **"даатгагч"** гэж Даатгалын тухай хуулийн дагуу даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан "МИГ Даатгал" ХХК-ийг;

2.1.2 **"даатгуулагч"** гэж өөрийн ашиг сонирхлын төлөө даатгалын зүйлээ даатгуулж, даатгагчтай гэрээ байгуулсан иргэн, хуулийн этгээд түүний ажиллагсадыг;

2.1.3 **"даатгалын баталгаа"** даатгалын зүйл, үнэлгээ, хугацааг тусгасан даатгалын гэрээ хийсэн тухайг нотолж даатгуулагчид олгосон баримт бичгийг;

2.1.4 **"даатгалын зүйл"** гэж гэрээнд заасан даатгуулагч, байгууллагын орчин дахь өдөр тутмын үйл ажиллагааны улмаас гуравдагч этгээдийн амь нас, эрүүл мэнд болон эд хөрөнгөд учирсан хохиролд хүлээх хуулийн хариуцлага / даатгуулагчийн ажиллагсдын мэргэжлийн хариуцлагаас үүдсэн хариуцлага биш болно / ;

2.1.5 **"даатгалын эрсдэл"** гэж даатгалын зүйлд хохирол учруулж болох үндсэн болон тусгай нөхцөлд заасан эрсдэлүүдийг;

2.1.6 **"даатгалын тохиолдол"** гэж даатгуулсан зүйлд учирсан хохирол, тохиролцсон болзол бүрдэхийг;

2.1.7 **"даатгалын хураамж"** гэж даатгуулагч даатгалын зүйлээ даатгуулсны төлөө даатгагчид төлөх төлбөрийг;

2.1.8 **"даатгалын нөхөн төлбөр"** гэж даатгалын тохиолдол үүссэн нөхцөлд даатгагчаас даатгуулагчид гэрээний дагуу олгох мөнгөн хөрөнгийг;

2.1.9 **"даатгалын үнэлгээ"** гэж даатгалын зүйлийн талууд харилцан тохиролцож тогтоосон мөнгөн илэрхийллийн хэмжээг;

2.1.10 **"өөрийн хүлээх хариуцлага"** гэж даатгалын тохиолдол бий болсон нөхцөлд даатгалын зүйлд учирсан хохирлоос даатгуулагчийн хариуцах хэсгийг;

2.1.11 **"гуравдагч этгээд"** гэж даатгалын гэрээнд оролцоогүй, даатгалын тохиолдолд эрх ашиг нь хөндөгдөж хохирсон этгээдийг;

2.1.12 **"хүндэтгэн үзэх шалтгаан"** гэж давагдашгүй хүчин зүйлс, хүнд нөхцөл байдал зэрэг талуудын хүсэл зоригоос үл хамааран гэрээний эрх, үүргийг хэрэгжүүлэх боломжгүй нөхцөл байдал үүссэнийг;

2.1.13 **"шүүхээр шийдвэрлүүлэхтэй холбогдон гарах зардал"** гэж даатгалын тохиолдлын улмаас учирсан хохирлыг төлүүлэх нэхэмжлэлийн дагуу үүссэн хэргийг хянан шийдвэрлэхтэй холбогдон гарсан, шүүхээр нөхөн төлүүлэхээр тогтоосон зардлыг;

2.1.14 **"тэмдэгтийн хураамж"** гэж даатгалын тохиолдлын улмаас учирсан хохирлыг төлүүлэх тухай нэхэмжлэл гаргах, шүүхийн шийдвэрт давж заалдах болон хяналтын журмаар гомдол гаргахад хуульд заасны дагуу төлөх улсын тэмдэгтийн хураамжийг.

2.1.15 **"нөхөн сэргээх үнэлгээ"** гэж даатгалын зүйл нөхөн сэргээгдэх, засварлагдахад гарах шууд зардлыг;

2.1.16 **"ажил гүйцэтгэгч"** гэж Даатгуулагчтай гэрээ байгуулсан тэдний бизнесийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой ямар нэг ажил, төсөл дээр хамтран ажиллаж, бусад туслан гүйцэтгэгчийг хянаж, зохицуулалт тавьж байгаа гэрээт ажил гүйцэтгэгчийг хэлнэ.

2.1.17 **"туслан ажил гүйцэтгэгч"** гэж ажил гүйцэтгэгчийн томилсон даатгуулагчийн бизнесийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой ямар нэг ажил, тосол дээр хамтран ажиллаж, төслийн тодорхой нэг хэсгийг гүйцэтгэж байгаа туслан ажил гүйцэтгэгчийг хэлнэ.

2.1.18 **"гуравдагч этгээд"** гэж даатгуулагч болон даатгуулагчаас бусад этгээдийг ойлгоно. Үүнд туслан ажил гүйцэтгэгч, түүний ажилчид орно.

2.1.19 **"даатгуулагчийн ажиллагсад"** гэж даатгуулагчтай хөдөлмөрийн гэрээтэй үндсэн ажилтан, хөлсөөр ажиллаж буй гэрээт ажилтныг ойлгоно.

2.1.20 **"эмчилгээний зардал"** гэж оношлогоо, нөхөн сэргээх эмчилгээний зардал, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлсэн эмнэлгийн үйлчилгээний хөлсийг хэлнэ.

2.1.21 **"нэг удаагийн тохиолдлын хязгаар"** гэж гэрээнд заасан эрсдлийн улмаас даатгалын тохиолдол үүсч тухайн хохиролд төлөх нөхөн төлбөрийн дээд хэмжээг.

2.1.22 **"хариуцлагагүй байдал"** гэж өөрийн хариуцлагагүй байдлаас болж бусдад учруулсан хохирол бөгөөд ердийн болон эрүүл саруул ухаантай этгээд тухайн нөхцөл байдалд авах, хэрэгжүүлэх байсан үйлдлийг гүйцэтгээгүйн улмаас бусдад учруулсан хохирол.

2.1.23 **"орчны бохирдуулалт"** гэж аливаа бохирдуулагч бодисын үр дагавар, нөлөө түүний нэвтрэлт, тархалт, нэвчилт түүнийг амьсгалах болон хэрэглэх мөн бохирдуулагч бодисын цаашдын тархалт хөдөлгөөнөөс учирсан хохирол;

## ГУРАВ. ДААТГАЛЫН ЗҮЙЛ

3.1 Даатгалын гэрээнд заасан даатгуулагч, байгууллагын орчин дахь өдөр тутмын, энгийн үйл ажиллагааны улмаас гуравдагч этгээдэд дараах байдлаар учирсан хохиролд хүлээх хуулийн хариуцлага. /Байгууллагад ажиллаж байгаа мэргэжлийн үнэмлэх, тусгай зөвшөөрөл бүхий ажиллагсдын мэргэжлийн үйл ажиллагааны улмаас үүдсэн хариуцлага биш болно. /

3.1.1 Гуравдагч этгээдийн амь нас, эрүүл мэнд;

3.1.2 Гуравдагч этгээдийн эд хөрөнгө;

3.2 Энэхүү даатгалын гэрээгээр Монгол Улсын нутаг дэвсгэрт Даатгуулагчийн гэрээнд заагдсан үндсэн үйл ажиллагаа, байр, ажил үүргээ гүйцэтгэж буй газарт үйлчилнэ.

## ДӨРӨВ. ДААТГАЛЫН ЭРСДЭЛ

4.1. Даатгалын зүйлийг дор дурдсан эрсдэлээс даатгана:

4.1.1. Даатгуулагчийн ажиллах орчин нөхцөлд гарах гэнэтийн осол аваар;

4.1.2. Ажил олгогчийн хөдөлмөр хуваарилалтын буруу зохион байгуулалт буруу удирдамж;

4.1.3. Даатгуулагчийн үйл ажиллагаандаа ашиглаж байгаа техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн эвдрэл тасалдал доголдол;

4.2. Даатгуулагч дараах нэмэлт хамгаалалтаар нэмэлт хураамжтай даатгуулж болно.

4.2.1. Байгаль орчны бохирдолт

4.3 Энэхүү даатгалын гэрээгээр Монгол Улсын нутаг дэвсгэрт Даатгуулагчийн гэрээнд заагдсан байр, ажил үүргээ гүйцэтгэж буй газарт үйлчилнэ;

## ТАВ. ДААТГАЛЫН ҮНЭЛГЭЭ, ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭ

5.1 Даатгалын үнэлгээг тухайн даатгуулагчийн бизнесийн үйл ажиллагааны болон тухайн мэргэжилтны ажил үүргийн онцлог, цар хүрээ, үйлчилгээний чиглэлээс хамааруулан харилцан тохиролцож тогтооно;

5.2 Даатгалын нөхөн төлбөр олгосон хэмжээгээр даатгалын зүйлийн үнэлгээ буурах бөгөөд даатгуулагч зохих хураамжийг нөхөн төлснөөр даатгалын үнэлгээг сэргээж болно;

5.3 Даатгалын хугацаанд даатгуулагч нөхөн төлбөр аваагүй тохиолдолд даатгагч хохиролгүйн хөнгөлөлт үзүүлж болно;

5.4 Даатгуулагч хураамжийг хэсэгчлэн төлж буй үед даатгалын тохиолдол бий болсон нөхцөлд даатгуулагчийн төлсөн хураамжид ногдох үнэлгээнээс нөхөн төлбөрийг тооцож олгоно;

5.5 Даатгуулагч гэрээнд заагдсан хураамжийг гэрээ байгуулагдсан өдрөөс хойш 3 хоногийн дотор Даатгагчийн Төрийн Банк дахь төгрөгийн 104400208536 тоот дансанд шилжүүлнэ.

5.6 Гэрээнд талуудын эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тогтоосон хугацаанд гэрээнд заасан дүнгээр даатгалын хураамж төлөгдсөнөөр гэрээ хүчин төгөлдөр үйлчилж эхлэнэ.

## ЗУРГАА. ДААТГАЛЫН ГЭРЭЭ, ХУГАЦАА, ГЭРЭЭ ДУУСГАВАР БОЛОХ НӨХЦӨЛ.

6.1 Даатгалын гэрээ байгуулахдаа тусгайлан заагаагүй бол гэрээг 1 жилээр байгуулна.

6.2 Гэрээний хөөн хэлэлцэх хугацаа энэхүү даатгалын гэрээний хугацаа дуусcанаас хойш 6 сар байна.

6.3 Даатгалын гэрээ дараах тохиолдолд дуусгавар болно.

6.3.1 Гэрээгээр тогтоосон хугацаа дуусгавар болсон;

6.3.2 Талуудын аль нэг нь дампуурсан, татан буугдсан;

6.3.3 Шүүх гэрээг хүчин төгөлдөр бус гэж тооцсон;

6.3.4 Гэрээнд заасан хугацаанаас өмнө гэрээг дуусгавар болгохоор талууд тохиролцсон;

6.3.5 Даатгагч гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлсэн.

6.3.6 Хоёр талын аль нэг нь гэрээг цуцлах тухай санаачлага гаргаж болох бөгөөд нөгөө талдаа мэдэгдсэнээс хойш 1 сарын дотор гэрээг цуцална.

6.4 Талууд даатгалын гэрээг хугацаанаас өмнө цуцалсан тохиолдолд гэрээний үлдсэн хугацаанд ногдох хураамжаас тухайн даатгалтай холбогдсон зардлыг хасаж, үлдэх хэсгийг даатгуулагчид эргүүлэн олгоно. Нөхөн төлбөр авсан болон 9 сараас дээш хугацаа өнгөрсөн тохиолдолд буцаалт хийхгүй.

## ДОЛОО. ДААТГУУЛАГЧ, ДААТГАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

**7.1 Даатгагчийн эрх, үүрэг:**

7.1.1 Даатгалын тохиолдол бий болсон үед нөхөн төлбөрийг хууль болон гэрээгээр тохиролцсон хугацаа, хэмжээнд олгох;

7.1.2 Даатгуулагч даатгалын хураамжийг хугацаанд нь төлөөгүй байхад даатгалын тохиолдол бий болсон бол даатгагч гэрээнд заасан үүрэг хүлээхгүй;

7.1.3 Даатгагч нь нөхөн төлбөр олгохоос татгалзсан бол татгалзсан үндэслэлээ тодорхой гаргаж, даатгуулагчид бичгээр мэдэгдэнэ;

7.1.4 Монгол улсын хуулиар зөвшөөрснөөс бусад нөхцөлд даатгуулагчийн талаарх мэдээ, материалын нууцыг задруулахгүй байх;

7.1.5 Даатгалын тохиолдол бий болсны улмаас учирч болох хохирлын хэмжээг багасгахын тулд даатгуулагчийн авсан арга хэмжээний өртгийг даатгалын нөхөн төлбөр дээр нэмж даатгуулагчид нөхөн төлөх;

7.1.6 Даатгуулагч нас барсан тохиолдолд түүний эрх, үүргийг хууль ёсны буюу гэрээслэлээр өв залгамжлагчид нь шилжүүлэх;

7.1.7 Хохирлын хэмжээг үнэн зөв тогтоох зорилгоор даатгуулагчтай бүх талаар идэвхитэй хамтран ажиллах;

7.1.8 Хариуцлагын даатгалаар даатгагч нь даатгалын хугацаанд үүсэх хариуцлагатай холбоотойгоор гуравдагч этгээдийн өмнө хүлээх үүргээс даатгуулагчийг чөлөөлөх үүрэгтэй.

7.1.9 Гуравдагч этгээдийн өмнө хариуцлага хүлээхэд хүргэсэн нөхцөл байдлыг даатгуулагч санаатай бий болгосон бол даатгагч гэрээгээр хүлээсэн үүргээс чөлөөлөгдөнө.

7.1.10 Даатгалын тохиолдол бий болсон үед даатгагч даатгалын тохиолдлын улмаас учирсан хохирлын шалтгаан нөхцөл, хэмжээг үнэн зөв тогтоолгох зорилгоор мэргэжлийн холбогдох байгууллагад хандаж дүгнэлт гаргуулах буюу нөхөн төлбөрийн хэмжээг тогтооход шаардлагатай аливаа мэдээг даатгуулагчаас шаардах эрхтэй.

7.1.11 Даатгалын тухай хуулийн 8.5-д заасан үндэслэлийн дагуу даатгалын нөхөн төлбөрийг бүрэн буюу хэсэгчлэн олгохоос татгалзах;

7.1.12 Даатгуулагчийн гаргаж өгсөн мэдээ, материалын үнэн, зөв эсэхийг шалгах, шаардлагатай бол мэдээллийн талаар эрх бүхий байгууллага, хуулийн этгээдээс тодруулга авах;

7.1.13 Даатгуулагчийн эрх үүрэг нь шинэ эзэмшигчид шилжих тохиолдолд даатгагч гэрээнд өөрчлөлт оруулах саналыг шинэ эзэмшигчид тавих;

7.1.14 Даатгуулагч хууль болон гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд гэрээг цуцлах, түүнд өөрчлөлт оруулахыг шаардах;

7.1.15 Даатгуулагч аюулыг санаатайгаар ихэсгэсэн, даатгалын зүйлд эрсдэл тохиолдох боломж энэхүү гэрээг байгуулах үеэд нэмэгдсэн, ийнхүү нэмэгдэх нөхцөл орчин бүрдсэн тохиолдолд даатгалын хураамжийн хувь хэмжээг ихэсгэх буюу гэрээг цуцлах саналаа даатгуулагчид тавих;

7.1.16 Даатгалын тохиолдол бий болохоос өмнө даатгуулагч даатгалын гэрээнээс татгалзсан бол даатгагч эрсдэлийг ооргоо хүлээж байсан хугацаанд тохирох даатгалын хураамж болон гэрээний дагуу үзүүлсэн үйлчилгээнийхээ хөлсийг даатгуулагчаас шаардах эрхтэй.

**7.2 Даатгуулагчийн эрх, үүрэг:**

7.2.1 Даатгалын хураамжийг энэхүү гэрээнд заасан хугацаа, хэмжээгээр Даатгагчид төлөх;

7.2.2 Даатгалын зүйлийг эрсдлээс урьдчилан сэргийлэх, даатгалын тохиолдол болсон үед хохирлыг багасгах зорилгоор боломжтой арга хэмжээ авах;

7.2.3 Даатгалын тохиолдол бий болсон тухай даатгагчид (Утас:7575-6000 /шуурхай алба, мэдээлэл зөвлөгөө/ Э-Шуудан ub6@mig.mn, албан бичиг зэрэг боломжтой арга хэлбэрээр) нэн даруй мэдэгдэх, шалтгааныг тогтоолгоход оролцуулах, даатгагч оролцох боломжгүй нөхцөлд түүний өгсөн заавар зөвлөмжийн дагуу шаардлагатай бүхий л арга хэмжээг авч баримтжуулах;

7.2.4 Даатгалын тохиолдол бий болсон үед энэхүү гэрээнд тусгагдсан баримт, материалыг даатгагчид үнэн зөв, бүрэн гүйцэд, хууль зүйн дагуу бүрдүүлэн, даатгалын тохиолдол бий болсон өдрөөс хойш хуанлийн 90 хоногийн дотор хүлээлгэн өгох;

7.2.5 Даатгуулагч нь гэрээ байгуулахдаа өөрийн мэдэж байгаа аюул учруулах буюу даатгалын тохиолдол бий болоход нөлөөлж болох ноцтой нөхцөл байдал, түүнчлэн гэрээ байгуулснаас хойш бий болсон нөхцөл байдал болон даатгалын тохиолдол бий болох таагүй нөхцөл орчин бүрдсэн тухай даатгагчид нэн даруй мэдээлэх үүрэгтэй;

7.2.6 Даатгуулагчийн ажилллагсад хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны норм, стандарт, дүрэм, журмыг мөрдөх;

7.2.7 Даатгуулагч нь аюулгүй ажиллагааны дүрэм журам, байгууллагын хөдөлмөрийн дотоод журмыг мөрдөж ажиллах;

7.2.8 Даатгалын тохиолдол болсон үед хууль болон гэрээний нөхцөлийн дагуу нөхөн төлбөр олгохыг даатгагчаас шаардах;

7.2.9 Даатгагч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд гэрээг цуцлах, эсвэл түүнд өөрчлөлт оруулахыг шаардах;

7.2.10 Шаардлагатай гэж үзсэн тохиолдолд даатгагчийн санхүүгийн чадавхийн талаар холбогдох мэдээ, мэдээлэл шаардах;

7.2.11 Даатгагчийн санхүүгийн чадвар муудсан гэж үзэх хангалттай үндэслэл бий болсон тохиолдолд гэрээг цуцлах саналыг даатгагчид тавих;

7.2.12 Даатгуулагч даатгалын тохиолдол болсны улмаас учирсан хохирлын шалтгаан нөхцөл, хэмжээг үнэн зөв тогтоохын тулд хууль, хяналтын байгууллага, цагдаа, галын байгууллага, эмнэлэг зэрэг мэргэжлийн байгууллагаар акт тогтоолгох;

7.2.13 Даатгуулагчийн эрх, үүрэг шинэ эзэмшигчид шилжих тохиолдолд шинэ эзэмшигч гэрээнд өөрчлөлт оруулах саналыг даатгагчид 30 хоногийн дотор тавих

## НАЙМ. ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР ОЛГОХ, ТООЦОХ НӨХЦӨЛ

8.1 Даатгалын нөхөн төлбөр олгох үйл ажиллагаа нь Монгол Улсын хууль болон тэдгээрт нийцүүлэн гаргасан журам, нөхцөл, заавар болон энэхүү даатгалын гэрээгээр зохицуулагдана;

8.2 Даатгуулагч нь даатгалын тохиолдлын үед дараах нөхөн төлбөрийн баримтуудыг бүрдүүлнэ:

- 8.2.1 Даатгалын гэрээ;
- 8.2.2 Нөхөн төлбөр хүссэн өргөдөл;
- 8.2.3 Даатгалын тохиолдол бий болсныг нотлох баримтууд, эд мөрийн баримтууд;
- 8.2.4 Даатгалын тохиолдол бий болсон шалтгааныг тогтоосон эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэр;
- 8.2.5 Хохирол үнэлгээний тайлан;
- 8.2.6 Нөхөн төлбөрийн хэмжээ болон нөхөн төлбөр авах эрх бүхий этгээдийг тогтоосон шүүхийн шийдвэр;
- 8.2.7 Шүүхээр шийдвэрлүүлэхтэй холбогдон гарсан зардлын баримт;
- 8.2.8 Гуравдагч этгээдийн даатгуулагчид гаргасан нэхэмжлэл;
- 8.2.9 Шаардлагатай бусад баримт, мэдээлэл;

8.3 Даатгалын хугацаанд олгогдох нөхөн төлбөрийн нийт хэмжээ даатгалын баталгаанд заасан даатгалын үнэлгээнээс хэтрэхгүй байна;

8.4 Шүүхээр шийдвэрлүүлэхтэй холбогдон гарах зардлын дээд хэмжээ нь тохиолдол бүрт гэрээнд заасан нэг удаагийн хариуцлагын хязгаарын 10 хувь хүртэл байна;

8.5 Даатгуулагчийн буруутай тохиолдолд өөрийн хүлээх хариуцлага 20 хувь байна;

8.6 Хэд хэдэн үйлчлүүлэгчид олгох нөхөн төлбөрийн хэмжээ нь энэ гэрээнд заасан хэмжээнээс хэтэрсэн бол үйлчлүүлэгч тус бүрт олгох нөхөн төлбөрийг хувь тэнцүүлэн олгоно;

8.7 Даатгуулагч гуравдагч этгээдийн эд хөрөнгө, амь нас, эрүүл мэндэд учируулсан хохирлыг нөхөн барагдуулах Монгол Улсын Иргэний хуулийн дагуу иргэний эрх зүйн хуулийн хариуцлага хүлээсэн эсвэл Даатгагч мэргэжлийн байгууллагын дүгнэлтээр батлагдсан нотлох баримтуудыг хүлээн зөвшөөрсөн тохиолдолд нөхөн төлбөр олгоно;

8.8 Даатгагч нь Монгол улсын шүүхийн шийдвэр, хохирлын хэмжээг тогтоосон эрх бүхий комиссын акт зэргийг үндэслэн нөхөн төлбөр олгоно. Шүүхийн шийдвэр нь эцсийн шийдвэр байх ба хэрэв даатгуулагч дараагийн шатны шүүхэд давж заалдах бол тухайн шатны шүүхийн шийдвэр гартал нөхөн төлбөрийг олгохгүй;

8.9 Даатгуулагч гуравдагч этгээдийн эд хөрөнгөнд материаллаг хохирол учируулсан тохиолдолд мэргэжлийн үнэлгээний байгууллагын дүгнэлтийг үндэслэн даатгагчийн сонголтоор гэмтсэн эд анги, хэсгүүдийг сэлбэг засварлах, нөхөн сэргээх, солих эсвэл мөнгөн хэлбэрээр нөхөн төлбөр олгоно;

8.10 Даатгуулагч гуравдагч этгээдийн эд хөрөнгө бүрэн сүйрсэн гэж үзэж, даатгагч нь нөхөн төлбөрийг бүрэн хэмжээгээр олгосон тохиолдолд даатгуулагч тухайн сүйрсэн хэсгийг даатгагчид шилжүүлнэ;

8.11 Хэрэв даатгалын тохиолдлоор гуравдагч этгээдийн амь нас, эрүүл мэндээрээ хохирсон мөн эд хөрөнгөнд нь хохирол учирсан нь нэг удаагийн тохиолдлын хязгаараас хэтэрч байвал бусдын амь нас, эрүүл мэндэд учирсан хохиролд үнэлгээний 60 хувь, үлдсэн 40 хувь нь эд хөрөнгийн хохиролд ногдоно;

8.12 Даатгагчаас олгогдох нөхөн төлбөрийн хэмжээ нь гэрээгээр тохирсон нэг удаагийн тохиолдлын хязгаарт багтаан шүүхийн шийдвэрт заасан дүнгээс даатгуулагчийн өөрийн хүлээх хариуцлагын хэмжээг хасч тооцсон дүнгээр хязгаарлагдана;

8.13 Даатгагч нөхөн төлбөрийн баримтуудыг хүлээн авч, шаардлага хангасан гэж үзвэл нэхэмжлэлийг ажлын 14 хоногийн дотор шийдвэрлэж нөхөн төлбөрийг олгоно.

8.14 Хэрвээ даатгалын нөхөн төлбөр авахад бүрдүүлэх материал бүрэн гүйцэд биш, 8.8-т шүүхийн шийдвэр эцэслэгдээгүй болон мэргэжлийн байгууллагуудаар хянагдаж байгаа бол 8.13-т заасан хугацааг сунгана.

8.15 Ерөнхий хариуцлагын даатгалд хамаарахгүй бусад хариуцлагын даатгал
- 8.15.1 Мэргэжлийн хариуцлага
- 8.15.2 Удирдах албан тушаалтан, эрх бүхий албан хаагчийн хариуцлага
- 8.15.3 Торгууль шийтгэл түүнтэй холбоотой зардал
- 8.15.4 Ажил олгогчийн хариулцлага
- 8.15.5 Тээвэрлэгч болон Зуучлагчийн хариуцлага.
- 8.15.6 Зорчигч тээвэрлэгчийн хариуцлага.
- 8.15.7 Аливаа байгаль орчны хариуцлага.

8.16 Дараах зүйлсийн өмчлөл, үйл ажиллагаа эсвэл хэрэглээ:
- 8.16.1 Цанын бааз.
- 8.16.2 Сургууль болон их дээд сургуулиуд.
- 8.16.3 Хог хягдал зайлуулах болон хаях.

8.17 Даатгалын тохиолдлын улмаас учирч болох хохиролын хэмжээг багасгахын төлөө даатгуулагчийн авсан арга хэмжээний зардлыг даатгагч даатгалын нөхөн төлбөр дээр нэмж даатгуулагчид нөхөн төлнө.

8.18 Энэхүү гэрээний 7.2.3, 7.2.4-д заасан хугацааг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хожимдуулсан тохиолдолд даатгуулагч нөхөн төлбөр нэхэмжлэх эрхээ алдах бөгөөд тэрээр хүндэтгэн үзэх шалтгаантай байсан гэдгээ нотолсоноор хугацааг сэргээнэ.

8.19 **Буруутай этгээдээс нэхэмжлэл гаргах.** Монгол Улсын Даатгалын тухай хуулийн 8.7, Иргэний хуулийн 443.7 дахь заалтыг үндэслэн Даатгагч нөхөн төлбөрийг олгосон нөхцөлд буруутай этгээдээс /гуравдагч этгээдээс/ төлбөр нэхэмжлэх даатгуулагчийн эрх нь даатгалаар олгогдсон нөхөн төлбөр, түүнтэй холбогдон гарсан зардлын хэмжээгээр даатгагчид шилжинэ.

8.20 Буруутай этгээдээс хохирлыг нэхэмжлэн авах даатгагчийн эрхийг даатгуулагчийн зүгээс ямар нэгэн хэлбэрээр хязгаарласан эсвэл багасгасан тохиолдолд даатгагч даатгуулагчид олгосон нөхөн төлбөрийг тэр хэмжээгээр буцаан нэхэмжлэнэ.

8.21 **Байгалийн гамшиг, гал, усны аюулаас хүний амь, эрүүл мэнд хохирсон, хөрөнгөд онц их хэмжээний хохирол гарсан даатгалын тохиолдолын үед.** Даатгалын тохиолдол бүрдсэн үед талууд зохих мэргэжлийн байгууллагуудтай хамтран хохирлын шалтгаан, хэмжээг тогтоох комисс томилон ажиллах ба комиссын бүрэлдэхүүнд даатгагч, даатгуулагчийн төлөөлөгч байхаас гадна шаардлагатай бол хууль хяналт, гал, ус цаг уурын албаны төлөөлөгч зэрэг холбогдох мэргэжлийн хүмүүсийг оролцуулж болно.

8.22 Томилогдсон комисс даатгалын тохиолдлын шалтгаан, хохирлын хэмжээг газар дээр нь шалган шинжлэн судалж, хохирлын шалтгааныг тогтоосон актыг үйлдэнэ.

8.23 **Зэрэг даатгагдах.** Даатгуулагч нь даатгалын зүйлийг хэд хэдэн компанид зэрэг даатгуулсан болон энэхүү даатгалын гэрээгээр олгогдох нөхөн төлбөр нь өөр даатгалын гэрээгээр мөн нөхөн төлөгдөхөөр байвал Даатгагч нь учирсан хохирлыг бүрэн хэмжээгээр хариуцахгүй бөгөөд бусад даатгалын компанитай тохиролцож хохирлын хэмжээнээс ихгүй байхаар тооцож нөхөн төлбөрийг олгоно.

## <u>ЕС. ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР ОЛГОХООС ТАТГАЛЗАХ НӨХЦӨЛ</u>

9.1 Даатгагч Монгол Улсын Даатгалын тухай хуулийн 8.5 дугаар зүйлд заасан үндэслэл үүссэн болон энэхүү даатгалын онцлогоос хамаарч дараах тохиолдлуудад аливаа үүрэг хариуцлага хүлээхгүй бөгөөд нөхөн төлбөр төлөхөөс татгалзана.
- 9.1.1 Даатгуулагч санаатайгаар хохирол учруулсан буюу даатгалын тохиолдол бий болох нөхцөл, орчныг бүрдүүлсэн;
- 9.1.2 Даатгуулагч даатгалын зүйлийн талаар даатгагчид худал мэдээлсэн, хуурамч бичиг баримт бүрдүүлсэн нь тогтоогдсон;
- 9.1.3 Гарсан хохирлыг даатгуулагч буруутай этгээдээр нөхөн төлүүлсэн;
- 9.1.4 Даатгалын гэрээнд заагдаагүй нөхцөл, эрсдэлийн улмаас гарсан хохирол;
- 9.1.5 Хууль тогтоомжид заасан бусад үндэслэл;

9.2 Даатгалын тохиолдол мөн эсэх нь нотлогдоогүй буюу нотлогдох боломжгүй болсон;
9.3 Хууль зөрчсөн үйл ажиллагаанаас үүдсэн хохирол түүний үр дагавар;
9.4 Ажил үүргээ гүйцэтгэж явсан ажилтан, ажил гүйцэтгэгч, туслан ажил гүйцэтгэгч, даатгуулагчийн ажиллагсдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд учирсан хохирол;
9.5 Даатгуулагчийн эрхэлж буй үйл ажиллагаа нь зохих лиценз, тусгай зөвшөөрөлгүй тохиолдолд гарсан аливаа хохирол;
9.6 Сайн дурын болон шууд хүлээн зөвшөөрсөн төлбөрүүд;
9.7 Салют үйлдвэрлэл, сум болон тэсрэх бөмбөг болон тосон бүтээгдэхүүн эсвэл шахмал болон шингэн хийний үйлдвэрлэлээс үүдэн гарсан хохирол;
9.8 Аливаа газар доогуурх уул уурхайн эрсдлүүд. Гэхдээ ил уурхайн хэсэг нь хасалт хэсэгт орохгүй.
9.9 Төлбөрийн чадваргүй болох эрсдэл.
9.10 Барилгын багана тулгуурыг авсан, сулруулснаас болон доргио чичиргээнээс үүдсэн хохирол;
9.11 Даатгуулагчийн өмчлөл болон итгэмжлэлд байгаа эд хөрөнгөд учирсан хохирол;
9.12 Даатгуулагчийн өөрийн хөрөнгөндөө хийсэн шаардлага хангаагүй, стандартын бус засварын ажлаас үүдсэн хохирол, түүний үр дагавар. Уг засварын ажлаас үүдэн үйлчлүүлэгч, гуравдагч этгээдийн бие эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учирсан бол энэ заалт хамаарахгүй.
9.13 Даатгуулагчаас ажилчдын нийгэм спортын арга хэмжээнд болон хоол унданд зориулан зарцуулсан бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээнээс үүдсэн хохирол;
9.14 Даатгуулагчийн өмнөөс ашиглаж байсан тээврийн хэрэгслийн механик гэмтэл эсвэл түүнээс холбогдон үүссэн гэмтэл бэртэл, хохирол;
9.15 Даатгуулагчийн ашиглаж байсан эд хөрөнгө, тоног төхөөрөмж, бараа материалын хэвийн элэгдэл, хорогдол, түүнээс үүссэн хохирол;
9.16 Техник тоног, төхөөрөмжийн ашиглалтын дүрэм, арчилгааны заавар зөрчсөн, ажиллах даац, ачаалал хэтрүүлснээс үүссэн хохирол;
9.17 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрэм, үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагааны журам заавры зөрчсөнөөс үүдэн гарсан хохирол;
9.18 Мэргэжлийн үйл ажиллагаа явуулахдаа тогтоосон журам зааварыг зөрчсөнөөс үүссэн хохирол;
9.19 Барилга, зам гүүр угсралтын үйл ажиллага явуулж буй компанид байгууллагын ерөнхий хариуцлагын даатгалаар нөхөн төлбөр олгохгүй.
9.20 Дайн, үймээн самуун, Ажил хаялт, террорист болон улс төрийн шинж чанартай үйл ажиллагаа, гэмт халдлага, нийгмийн эмх замбараагүй байдал, бослого, төрийн захиргааны байгууллагын акт шийдвэр зэргийн улмаас үүссэн нөхцөл байдал, улс төрийн тэмцэлд оролцсоноос үүссэн;
9.21 Байлдааны зэвсэг хэрэглэх, цөмийн дэлбэрэлт, цацраг идэвхт бодис буюу туяаны нөлөө, цөмийн хаягдал, цөмийн зэвсгийн материал, цөмийн шатахуунаас гарах радиоидэвхт бохирдол юм уу үүнээс үүсэх ионжсон цацраг түүний үр дагавар;
9.22 Дараах төрлийн бараа, бүтээгдэхүүний хэрэглээ, үйлдвэрлэл, ашиглалттай холбогдон гарсан хохирол; Асбестос, бүх төрлийн зэвсэг, сум, салют, тэсрэх, дэлбэрэх бодис, бүтэгдэхүүн, газрын тосны бүтээгдэхүүнүүд, шатахуун түгээх станци, агаарын хөлөг, усан онгоц, нисэх онгоц, хорголтийн тээврийн хэрэгсэл;

## АРАВ. ГЭРЭЭНИЙ ХАРИУЦЛАГА, НУУЦЛАЛ

10.1 Талууд гэрээний хугацаанд ажил үүргийн шаардлагаар олж мэдсэн, эзэмшиж, ашиглаж байсан баримт бичиг, мэдээ материал болон талуудын бизнесийн ашиг сонирхолд шууд болон шууд бус хамааралтай компанийн болоод харилцагчийн үйл ажиллагаатай холбоотой бүх төрлийн мэдээлэл, даатгалын хэмжээ, төлбөр, тооцоо, бусад үзүүлэлтүүд, байгууллага, хувь хүний нууц, ноу-хау зэргийг хуульд зааснаас бусад тохиолдолд задруулахгүйгээр хугацаагүй чанд хадгална.
10.2 Даатгуулагч нь даатгалын нөхөн төлбөр авах зорилгоор нотлох баримтыг хуурамчаар үйлдсэн, бүрдүүлсэн бол даатгагчаас гэрээг цуцалж, хариуцлага хүлээлгэхээр баримтыг хуулийн байгууллагад шилжүүлнэ.
10.3 Даатгалын нөхөн төлбөрийн материалыг бүрэн хүлээн авсан болохоо даатгуулагчид мэдэгдэж хариу өгсөнөөс хойш гэрээний хугацаанд нөхөн төлбөр олгоогүй тохиололд иргэний хуулийн 232.6 дахь хэсэгт заасны дагуу хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,5 хувиар алданги тооцож олгоно.

## АРВАН НЭГ. БУСАД

11.1 Талууд энэхүү гэрээг хэрэгжүүлэхдээ Монгол улсын хууль тогтоомжинд заасдсан эрхийг эдэлж, үүрэг хүлээнэ. Энэхүү гэрээг Монгол хэлээр хууль зүйн хувьд адил хүчинтэй 2 эх хувь үйлдэж талууд нэг нэг хувийг хадгалав.
11.2 Талууд харилцан тохиролцож гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болох ба энэ нэмэлт өөрчлөлтийг энэхүү гэрээнд зөвхөн бичгээр оруулж гарын үсэг зурж баталгаажуулснаар хүчин төгөлдөрт тооцно.

11.3 Энэхүү гэрээ түүний гүйцэтгэлтэй холбоотой асуудлаар талуудын хооронд маргаантай асуудал үүсвэл, юуны өмнө эв зүйгээр шийдвэрлэхийг эрмэлзэнэ. Хэрэв ийнхүү шийдвэрлэж чадахгүйд хүрвэл талууд Монгол улсын шүүхэд хандаж шийдвэрлүүлнэ.

**НӨХӨН ТӨЛБӨРИЙН АЛБАТАЙ ХОЛБОГДОХ УТАС, ХАЯГ:**

**Хаяг:** МОНГОЛ УЛС, Улаанбаатар 15170, Чингэлтэй Дүүрэг, Энхтайвны өргөн чөлөө 5/1, МИГ даатгал компанийн байр.
**24 Цагийн шуурхай албаны утас:** (+976)-7575-6000
**Төв компанийн утас:** (+976)-7575-6000 /Мэдээлэл, асуулт хариулт, зөвлөгөө/
**Э-Шуудан:** claim@mig.mn

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

| | |
|---|---|
| Даатгагчийн төлөөлж: | Даатгуулагчийг төлөөлж: |
| "МИГ ДААТГАЛ" ХХК-ийн | "ҮНЭН АНД" ХХК-ийн |
| УБ-6 салбарын ахлах менежер | Захирал |
| ........................ Ж.Оюун-Эрдэнэ | ........................ Т.Төмөрсоль |

МИГ ДААТГАЛ ХХК
УЛААНБААТАР 6 САЛБАР
Сүхбаатар дүүргийн 3-р хороо, 5 хороолол, Ус-3 41 тоот
Утас : +7010 7100
Ц/хуудас: www.mig.mn
Ц/шуудан : ub6@mig.mn

# ГЭНЭТИЙН ОСЛЫН ДААТГАЛЫН ГЭРЭЭ

# № D24155003

**БАТЛАВ:**

**Даатгагчийн төлөөлж:**

**“МИГ ДААТГАЛ” ХХК-ИЙН ЗАХИРАЛ**
**Б.МӨНГӨНЦӨГЦ**

..........................

**Даатгуулагчийг төлөөлж:**

**“ҮНЭН АНД” ХХК-ИЙН ЗАХИРАЛ**
**Т.ТӨМӨРСОЛЬ**

..........................

**MIG ДААТГАЛ**

ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

2024 оны 4-р сарын 15-ны өдөр | Дугаар D24155003 | Улаанбаатар хот

| | |
|---|---|
| **ДААТГАЛЫН ХЭЛБЭР:** | Гэнэтийн ослын "БАДМААРАГ" даатгал |
| **ДААТГАГЧ:** | "МИГ ДААТГАЛ" ХХК |
| **ДААТГУУЛАГЧ:** | "ҮНЭН" ХХК |
| **ДААТГУУЛАГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА:** | Уул уурхай, Барилгын ажил |
| **ДААТГАЛЫН ЗҮЙЛ:** | Даатгуулагчийн ажиллагсдын амь нас, эрүүл мэнд. |
| **ДААТГАЛЫН ХАМГААЛАЛТ:** | Гэрээнд заагдсан эрсдэлээс хамгаална. |
| **ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА:** | 2024 оны 04 сарын 15-ний өдрөөс<br>2025 оны 04 сарын 14-ний өдрийн 24:00 цаг хүртэл хүчин төгөлдөр байна. |
| **ДААТГАЛЫН ҮНЭЛГЭЭ:** | Нэг ажилтны үнэлгээ 40 000 000 төгрөг<br>Нийт ажилтны тоо 5<br>Нийт даатгалын үнэлгээ 200 000 000 төгрөг |
| **ДААТГАЛЫН ХУРААМЖ:** | Нэг хүний хураамж 400 000 төгрөг<br>Нийт даатгалын хураамж 2,000,000 төгрөг |
| | **Нийт хураамж 2,000 000 төгрөг** |
| **ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ:** | Монгол Улсын холбогдох хууль, дүрэм журмыг баримтална. |
| **ГАЗАР НУТГИЙН ХЯЗГААР:** | Монгол Улс |

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

| | |
|---|---|
| Даатгагчийг төлөөлж:<br>"МИГ ДААТГАЛ" ХХК-ийн<br>Салбарын ахлах менежер<br>Ж.Оюун-эрдэнэ<br>…………………… | Даатгуулагчийг төлөөлж:<br>"ҮНЭН АНД" ХХК-ийн<br>Захирал<br>Т.Төмөрсоль<br>…………………… |

## НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1. Энэхүү даатгалын гэрээгээр (цаашид "Гэрээ" гэх) Даатгуулагч Гэрээнд заасан даатгалын зүйлээ Даатгагчид даатгуулж хураамж төлөх, Даатгагч нь даатгалын тохиолдол учирсан үед гарсан хохирлыг гэрээнд заасан нөхцөлийн дагуу нөхөн төлөхтэй холбоотой харилцааг зохицуулна.

1.2. Гэнэтийн ослын "Бадмаараг" даатгалын гэрээ нь гэрээний тусгай нөхцөл, үндсэн нөхцөл болон гэрээний хавсралтуудаас бүрдэнэ.

1.3. Гэрээний тусгай нөхцөлд Гэнэтийн ослын "Бадмаараг" даатгалын гэрээний үндсэн нөхцөлөөс өөрөөр заасан бол тусгай нөхцөлийн заалтыг дагаж мөрдөнө.

